





Ажилчин авна

**ШИГДЭХ ҮҮ,
ШИНЭЧЛЭГДЭХ ҮҮ**



Handwritten signature
12

“МОНГОЛИАН ЮНИВЕРСАЛ ДРИЛЛИНГ” ХХК

M.U.D

Mongolian Universal Drilling LLC



- 2010 оны 12 сарын 21-нд Монгол Улсын уул уурхай, эрдэс баялгийн салбарт геологи хайгуулын өрөмдлөгийн үйлчилгээ үзүүлэх зорилгоор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж эхэлсэн.
- Боловсон хүчний хувьд 5-32 жил ажилласан туршлагатай мэргэшсэн инженер, техник, өрмийн мастер зэрэг 200-гаад ажиллагсадтай уул уурхайн салбарын үндэсний тэргүүлэгч компани юм.
- Байгуулагдсан цагаасаа хойш тасралтгүй геологи, уул уурхайн компаниудын захиалгын дагуу өндөр хүчин чадал бүхий 1300А НҮДХ-5А фирмийн өрөмдлөгийн машин болон Урал-375 бүхий арав гаруй машин түүнийг дагалдах техник, тоног төхөөрөмжүүдийг ашиглан хийж гүйцэтгэж байна.
- “M.U.D” ХХК нь хөдөлмөр хамгаалал, эрүүл мэнд, аюулгүй техник үйл ажиллагааны дүрэм журмыг чанд сахиж, хээрийн ангийн ажилчдын ажил амралтыг Монгол Улсын хөдөлмөрийн хуулийн дагуу баримтлан ажиллаж аюулгүй, эрүүл чанартай ажил үйлчилгээг үзүүлнэ.

- Говьсүмбэр аймгийн Шивээ-Овоо суманд нүүрс, ураны хайгуул /17800 тууш метр/
- Дархан-Уул аймгийн Хонгор суманд зэс төмрийн хайгуул /25000 тууш метр/
- Хөвсгөл аймгийн Цагаан-уул суманд молибдений хайгуулын өрөмдлөг /10100 тууш метр/
- Өмнөговь аймгийн Гурван тэс суманд нүүрсний хайгуулын ордын өрөмдлөг /3000 тууш метр/
- Увс аймгийн Хяргас суманд алт, зэсийн ордын хайгуулын өрөмдлөг /5000 тууш метр/
- Дорноговь аймгийн Хөвсгөл суманд алт, зэсийн ордын хайгуулын өрөмдлөг /1200 тууш метр/
- Өвлийн нөхцөлд Шинэ шивээ ХХК-ийн захиалгаар 750 м гүнтэй цооногийг үр дүнтэй өрөмдсөн
- Дархан-Уул аймгийн Төмөр толгой ордод /2800 тууш метр/
- 2012 оны эхний хагаст өрөмдлөгийн ажлыг гүйцэтгэсэн тууш метр
- Төв аймгийн Баян Цогт суман дахь төмөр полиметалл ордын хайгуулын өрөмдлөг /7800 тууш метр/
- Сүхбаатар аймгийн Эрдэнэ Цагаан суманд нүүрс занарын ордын хайгуулын өрөмдлөг /18800 тууш метр/
- Дорнод аймгийн Баян Уул суман дахь төмрийн хүдрийн ордын хайгуулын өрөмдлөг /12542 тууш метр/

Бид геологи хайгуул, өрөмдлөгийн ажлыг зах зээлийн хамгийн бодит үнэ чанараар үйлчилгээ үзүүлнэ



Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Тээвэрчдийн гудамж, Нарны зам-89,
ШХ: УБ-210523, Төв шуудан 23 Хайрцаг-336

е-мэйл:drilling_999@yahoo.com
www.mdtoe.com
факс: 976-5011-5066
Утас: 8811-4895, 8811-6905, 9905-0706



“Уурхайн гүнээс аваргын энгэрт” үзэсгэлэн

Оюу Толгойн мэдээллийн төвд нээгдсэн “Уурхайн гүнээс аваргын энгэрт” үзэсгэлэн үргэлжилж байна. Үзэсгэлэнд 2012 оны Олимп, Паралимпийн наадмын үеэр гардуулагдсан медалиуд хэрхэн хийгдсэн талаарх түүхийг өгүүлсэн болно.

Үзэсгэлэн 10 сар хүртэл үргэлжилнэ. Та бүхнийг үзэсгэлэнд хүрэлцэн ирж медалийн түүхтэй танилцахыг урьж байна.

Хаяг:

Оюу Толгойн Мэдээллийн төв
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Бага Тойруугийн гудамж
Одкон Холдинг байр, 1-р давхар
(МУИС 4-р байр, Эдийн засгийн сургуулийн баруун талд)

Утас +976-11-353366

Цагийн хуваарь: Даваа - Бямба 9.00 - 18.00

уурхайн гүнээс
аваргын энгэрт



**MINING 2012
MONGOLIA**



**BUILDING &
CONSTRUCTION
MONGOLIA 2012**



2012 оны 9 дүгээр сарын 5-7
Буянт-Ухаа Спорт цогцолбор, Улаанбаатар хот

ҮНЭ ТӨЛБӨРГҮЙ ҮЙЛЧЛЭХ АВТОБУСНЫ ХУВААРЬ:

2012 оны 9-р сарын 5-7 өдөр

1. УЛААНБААТАР - БАЯНГОЛ – ПАЛАС - ҮЗЭСГЭЛЭН

Хөдлөх цаг:

Улаанбаатар зочид б уудал 08.20А.М- 9.30А.М-10.20А.М-01.20Р.М

Зочид буудлуудын хооронд 10 минут явах ба буудал тус бүр дээр

10 минут хүлээнэ гэдгийг анхаарна уу. Жишээ нь: 08.20а.м-

Улаанбаатар зочид буудалд ирэх 08.30А.М хөдлөх, 08.40а.м-

Баянгол ирэх, 08.50а.м-д хөдлөх гэх мэт.

2. РАМАДА ЗОЧИД БУУДАЛ - ҮЗЭСГЭЛЭН

Хөдлөх цаг:

08.20А.М -10.20А.М-01.20Р.М



Гайхалтай боломжуудад хүргэх таны УРИЛГА

**3 өдрийн турш шинэ боломж,
шинэ санаа, дэлхийн 22 орны 190
компани, Монголд анх удаа
хамгийн өргөн хүрээний
технологийн үзэсгэлэн болно.**

**Үзэсгэлэнгийн
цагийн хуваарь:**

2012 оны 9 сарын 5-6 10:00-17:00

2012 оны 9 сарын 7 10:00-16:00

Үзэсгэлэн зохион байгуулагдах газар:
Буянт-Ухаа Спорт цогцолбор



AN
ALLWORLD
EXHIBITIONS
EVENT



Уул уурхайн
яам



Барилга, хот
байгуулалтын яам



Зам тээврийн яам



www.miningandconstructionmongolia.com

Холбоо барих :
(976-11) 34 44 88 Email: sales@lookmongolia.com

Шандон Тоног Төхөөрөмж ХХК Автогрейдэрийн худалдаа, урамшуулал



КАТЕРПИЛЛАРЫН
ДИЗАЙНЫ ШИЙДЭЛ

+

АЖЛЫН ӨНДӨР
БҮТЭЭМЖ

+

ӨРСӨЛДӨХҮЙЦ ҮНЭ,
БОДИТ ХЭМНЭЛТ

+

**2000 + 500 МОТО/ЦАГ
БАТАЛГААТ ЗАСВАР**

+

2000 МОТО ЦАГИЙН
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ МАТЕРИАЛ
ҮНЭГҮЙ



Утас: 99991586
99007826

www.shandongequipment.com

Боомилогдсон боловсрол



...Кембриж систем гээч Монголын боловсролын салбарыг гэнэт л өөрчилж, дэлхийн хэмжээнд аваачиж, аварчих юм бодож суугаа бол том эндүүрэл болох байх. Харин багш шавийн нандин холбоо, хамтрах, бие биенийхээ оюуны өдөөгч байх замыг засаж, өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлсэн нь зөв болох болов уу...12

Боловсролын авлига буюу түнтгэр дугтуй

Ачааллаа дийлэхгүй байхад юун хүүхэд нэмж авах” гээд халгаахгүй. Халгаахгүй ч гэж нүдээрээ харж байхад ялангуяа цэцэрлэгүүдийн эрхлэгч нар халгаахгүй байхаас аргагүй нөхцөл байдал өнөөдөр үүсээд буй...19



Мэдлэгийн эрин үеийн сургалт



Хөгжилтэй, хөгжиж буй, буурай гээд бүх л улс орон өөрийн боловсролын тогтолцоо, шинэчлэлд анхаарал хандуулдаг. Дэлхийд аль улс сурлагын түвшингээр тэргүүлдэг бол? Тэгвэл дэлхий дахинаа энэхүү үзүүлэлтийг хэмжиж, орнуудыг сурлагаар нь жагсаадаг хөтөлбөр байдаг байна...30

Шинэ салхи

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь тус компанийн үйл ажиллагааг хэмжих хэмжүүр аж..46



БОЛОВСРОЛ

- 12 Шигдэх үү, шинэчлэгдэх үү
- 13 Боомилогдсон боловсрол
- 16 Орхигдогсод
- 19 Боловсролын авлига буюу түнтгэр дугтуй
- 22 Хөдөлмөрийн зах зээлийн парадокс
- 25 Багш Та...
- 26 Боловсрол
- 30 Мэдлэгийн эрин үеийн сургалт
- 33 Финландын боловсролын шинэчлэлээс сурах юм их байна
- 35 “Элит сурагчдад” элит болох боломжийг нээх хаалга
- 38 Монголын баялаг боловсролын боломжийг хязгаарлах ёсгүй
- 40 Дээд боловсролын хөгжил Монголд

ЭДИЙН ЗАСАГ

- 42 Инфляцын бууралтыг боловсролын салбар хадгалж чадах уу
- 44 Шинэ салхи

ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ И.ОТГОНЖАРГАЛ

Хожуу төрүүлсэн аминаас минь хүнэтэй охин үр маань хичээлийн шинэ жилтэй зэрэгцэн хоёр нас хүрэв. Цэцэрлэгт оруулахад олон аавын багачуултай ажрахгүй хүмүүжих байх аа гэж аав, ээж хоёр нь охиноо хоёр ойндоо хүрэхийг нь хүлээж суулаа.

“Цэцэрлэгт өгвөл яах бол л” гэж бодож байсан болохоос цаг нь болоод албанд оруулах амаргүй гэдгийг гадарлаж байгаагүй юм байна лээ. “Хүүхдэд мөнгө зарах насан дээр нь л зар. Сайн ч муу ч улсын цэцэрлэгүүдэд хүүхэд хүмүүжүүлэх сургалтын стандарт гэж нэг тогтсон зүйл байдаг. Тэгээд ч олон хүүхэдтэй тоглож наадах нь нийгэмшиж, төлөвших талдаа илүү байдаг юм. Хэрвээ чи бага насны хүүхэдтэй бол энэ үгийг авахад илүүдэхгүй шүү. Эгч нь 20-иод жил цэцэрлэгийн эрхлэгч хийж байна даа” гэж хоёр жилийн өмнө гудамжинд зам нийлэн алхах зуураа хуучлаад өнгөрсөн огт танихгүй эмэгтэйн хэлсэн үг яагаад ч юм сэтгэлд ойр үлдсэн юм даг.

2012.08.22-24. Энэ тоо цэцэрлэгийн насны хүүхэдтэй олон аав ээжийн сэтгэлд тод толботой үлдсэн байх. Улаанбаатар хотын улсын гэсэн тодотголтой бүх цэцэрлэг эл өдөр хичээлийн шинэ жилийн бүртгэлээ явуулсан. Бөөн хэл ам хэрүүл тэмцэл, арын хаалга, авлига, хүнд суртал дагуулсан өдрүүд үргэлжлэх нь тэр. Би ч дээрх сэтгэлийн гүнд хоногшсон танихгүй эмэгтэйн зөвлөсний дагуу эл өглөө СХД-ийн Тамгын газартай хаяа нийлэн байрладаг харъяаныхаа 156 дугаар цэцэрлэгт охиноо бүртгүүлэхээр эрт гэгч нь очив. Эхний гурван хүний нэг байсан ч “Шинэ хүүхэд огт бүртгэхгүй гэсэн зар олон хоногийн өмнө хаалган дээр наасныг хараагүй юм уу. Манайх өнгөрсөн жил ашиглалтад орсон шинэ цэцэрлэг. 100-хан хүүхдийн багтаамжтай. Нэг ч хүүхэд шинээр бүртгэхгүй. Урилгатай хуучин хүүхдүүдээ л бүртгэнэ. Та нар ингэж зогсоод нэмэргүй ээ” гэдэг үгээр

шавхуурдуулав. “Яагаад шинээр огт хүүхэд бүртгэхгүй гэж. Танайхаас тодорхой тооны хүүхэд нэгдүгээр ангид орж байгаа биз дээ. Ядаж эхний хэдэн шинэ хүүхдийг бүртгэхийг л дээ. Арав хүрэхгүй л хүн байна шүү дээ. Харъяаныхаа цэцэрлэгт хүүхдээ оруулахгүй өөр хаана өгөх болж байна” хэмээн олон эцэг, эх бухимдаж, учирлаж янз бүрээр үзсэн ч тусыг эс олсон.

Гэрийнхээ хажуу байранд байрладаг хувийн цэцэрлэгт л хүүхдээ өгөхөөс гээд бардам буцлаа. Харамсалтай нь хаалга мөргөв. Хөршийнх нь хаалгаа нээж, зөлдөг эмэгтэй “Энэ цэцэрлэгийн зөвшөөрлийг нь өгөх, өгөхгүй нь тодорхойгүй байгаа гэсэн. Нөгөө байранд цэцэрлэг нээгдэж байгаа сураг байна лээ. СӨХ-ийн хүнээс асуу. Хар даа, цаад талын чинь хаалган дээр Манайх цэцэрлэг биш гээд бичээд наасан байгаа биз дээ. Хэцүү байдаг юм” гэж инээмсэглэв. Цэцэрлэгт хүүхэд өгнө гэдэг амаргүй ажил болохыг ингэж мэдэв.

Ганц манай харъяаны цэцэрлэг ч биш, энэ жил хаа сайгүй л цэцэрлэгүүд бараг харуул хамгаалалттай шахуу 2-3 өдрийн бүртгэл хийв. “Нэг айлаас нэг л хүүхэд авна. Хүүхэд шинээр цэцэрлэгт өгөх гэж байгаа бол Та хожимджээ. Эхний өдөр ирсэн 10 хүүхдийг аваад бүртгэл дууссан” гээд янз янзын л шалтгаг шалтгаан хэлж байгаа дуулдав, хүмүүсийн ярианаас сонсоход. Ямар сайндаа нэг найз маань “Хүүхэд цэцэрлэгт өгөх хэцүү. Сургуульд оруулах бүр ч хэцүү. Цэцэрлэгийн эрхлэгч нар энэ өдрүүдэд Ерөнхийлөгч, Ерөнхий сайд шиг л сэнтийдээ залрана шүү дээ. Тэд чинь бүртгэлийн үеэр бараа нь харагдах нь битгий хэл толгойгоо ч өрөөнөөсөө цухуйлгахагүй” гэж инээдэм болгохов. Үнэхээр л тийм байхаар дүр зураг энд тэндгүй ажиглагдсан. Бас нэг танил маань алтан гахай жилийн хүүхдүүд сургуулийн өмнөх бэлтгэл бүлэгт олноороо ороод цэцэрлэгүүдийн ачаалал эрс нэмэгдсэн гэсэн” гэж сонирхуулав. Тийм тал байж ч



болох. Тэр жил нээрээ төрөлт эрс нэмэгдсэн тухай амтай бүхэн ярьж, сонин хэвлэлд хүртэл бичиж байсан удаатай.

Улаанбаатар хотын хэмжээнд нийт хэдэн цэцэрлэг байдаг болоод ингэж их асуудал үүсгээд олон түмнийг бухимдуулаад байгаа юм бол гэдгийг сонирхож, тооны араас хөөцөлдөө.

Нийслэлийн хэмжээнд өнгөрсөн жил 308 цэцэрлэг үйл ажиллагаа явуулжээ. Үүнээс 180 нь төрийн өмчийнх байсан бол 128 нь хувийнх байв. Түүнчлэн 58 хувийн цэцэрлэгүүд хаалгаа шинээр нээж, 1200 хүүхэд хамруулах боломжтой болсон сайн мэдээ дуулдав. Мөн Баянзүрх дүүргийн 64, Сүхбаатар дүүргийн 14 дүгээр цэцэрлэгт өргөтгөл ▶



► барьснаар хамрагдах хүүхдийн тоо 125-аар нэмэгдсэн гэнэ.

Цэцэрлэгийн бүртгэлийн араас нь их, дээд сургуулийн бүртгэл, хөдөлмөрийн зах зээлд шилжигсэд гэнэт ухаарсан мэт ажил төрөл олох гэж гүйлдэн, хөдөөнөөс оюутнууд ирж, хотын хөл хөдөлгөөн ихсэв.

“Юу юугүй л есдүгээр сарын 1 болох гээд байгаа юм шиг адгаад байсан чинь ажлаа зохицуулаад харсан чинь бараг 14 хоногийн хугацаа байгаа юм байна шүү дээ. Цэцэрлэгийн бүртгэл эрт эхлээд л хүмүүсийг яаруулаад хаячихлаа” гэж оюутан болж байгаа дүү маань хуучлав. Нээрээ бодсон чинь тэгсэн болж таарлаа. “Жил бүрийн наймдугаар сарын дөрөв

дэх долоо хоногт цэцэрлэгийн хүүхдийг бүртгэх тухай Нийслэлийн боловсролын газрын даргын зөвлөмж байдаг нь энэ жил эрт таарсан тухай Нийслэлийн боловсролын газрын Сургуулийн өмнөх боловсрол хариуцсан мэрэгжилтэн З.Болормаа сэтгүүлчид тайлбарлажээ. Өмнө нь цэцэрлэгийн бүртгэл наймдугаар сарын 28, 29 гэж эхлээд л чимээ шуугиан багатай болдог байсан чинь энэ жил бүртгэх хугацаа нь эрт байсан биш, эцэг эхчүүдийг илүү олон хоног бухимдуулж, цэцэрлэгийн багш, эрхлэгч, ажилтнууд өмнө байгаагүйгээрээ хүнд суртал гаргав. Тэд дарга, цэрэггүй гарсан ч, орсон ч хаалгаа дангинатал нь түгжээстэй. Зарим нь зориулалтын бус газар

жижигхэн хаалга гаргаж бүртгэх жишээний.

Цэцэрлэгийн тухай томчуудын ярианаас охин маань ойлгосон уу, зөн совингоороо ч тэр үү “Би цэцэрлэгт явна” гэж уулзсан, өхөөрдсөн хүн бүрт шахуу хэлэх нь хөөрхөн. Аав ээж хоёр нь охиндоо ямар ч гэсэн цэцэрлэг олсоон. Харин танил тал, ах дүү муутай, орлого багатай гэр хорооллын хэчнээн эцэг эх бяцхан үрийнхээ хөөрсөн сэтгэл, хорвоотой танилцах хүслийг нь биелүүлж чадахгүй бухимдаж суугаа бол доо үр минь. Чамайг минь том болтол сургууль цэцэрлэгийн хангамж хүрэлцээ сайжирч, боловсролын асуудал эмх цэгц, чанар стандарттай болоосой. ■

ЭДИЙН ЗАСАГ

Дэлхийн банкны мэдээлснээр байгалийн гамшиг болоод эрчим хүчний үнийн өсөлтөөс шалтгаалан хүнсний бүтээгдэхүүний үнэ дэлхийн зах зээл дээр өсөх хандлагатай байгаа аж.

Үнийн өсөлт нь эдийн засгийн чадавх дорой, хөгжил буурай орнуудад тулгамдсан асуудал болж байгаа юм. Энэ оны зургаа, долдугаар сард улаан буудай, овъёосны үнэ 25 хувиар өсчээ. Харин буудайны үнэ дөнгөж дөрвөн хувиар л буурсан үзүүлэлттэй гарсан байна. Түүнчлэн Дэлхийн банкнаас дэлхийн аль ч улс орны Засгийн газрууд үнийн өсөлт ард түмний нуруун дээр үүрүүлэхгүй байх уян хатан бодлого баримтлахыг сануулжээ.

ЭРЧИМ ХҮЧ

Засгийн хуралдаанаар дизель түлшний тонн тутамд 109 мянган төгрөгийн онцгой албан татвар ногдуулахаар



шийдвэрлэлээ. Ингэснээр төсөвт 30 орчим тэрбум төгрөг орох боломж бүрдэж аж. Татвар авах болсноор аж ахуйн нэгжүүдийн орлого тодорхой хэмжээгээр буурч, таван хувийн ашигтай ажиллана. Хамгийн гол нь дотоодын жижиглэнгийн үнэд өөрчлөлт орохгүй. Харин ч цаашид хилийн үнэ нэмэгдэх тохиолдолд дотооддоо үнэ нэмэлгүй зохицуулж байх боломжийг Засгийн газар бүрдүүлнэ хэмээн үзжээ.

БАНК САНХҮҮ

Хөгжлийн банкинд буй хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг нэгээс зургаан сар хүртэл хугацаатайгаар Төвбанк, Засгийн газрын үнэт цаас болон арилжааны банкуудад баталгаажсан байршуулахаар боллоо. Хөгжлийн банк 5.75 хувийн хүүтэй, 600 сая ам.долларын эх үүсвэртэй болсон ч өнөөдрийн байдлаар хүүнд нь 20 орчим тэрбум төгрөг төлөх болоод байна. Өдөр бүр их хэмжээний хүү төлж байгааг зогсоох үүднээс Засгийн газар дээрх шийдвэрийг гаргажээ. Банкны хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг үнэт цаас, хадгаламж хэлбэрээр байршуулснаар энэ оны эцэст 15 тэрбум, “Эрдэнэс Тавантолгой” компанид 300 сая ам.доллар олгож 3.1 тэрбум, нийт 18.1 тэрбум төгрөгийн хүүгийн орлого олох боломжтой гэсэн тооцоог хийсэн байна.

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

АНУ-ын “Файрберд менежмент” хөрөнгө оруулалтын сан Монголын хөрөнгийн биржид бүртгэлтэй дөрвөн хувьцаат компанийн менежментийг нь хийхээр болжээ. Юун түрүүнд тус сан “Шарын гол” компанийн багц хувьцааг эзэмшиж, менежментийг нь хийх болсон. Ингэснээр “Шарын гол” компани нэмэлт хайгуул хийж, нөөцөө Жорк стандарт руу шилжүүлээд байгаа аж. Мөн “Бэрх-Уул” компанийн багц хувьцааг худалдан авч, компанийг шинэчлэн зохион байгуулж буй. Тус компани нь жонш, нүүрсний ордын нөөцөө олон улсын стандартад нийцүүлэн батлуулахаар зэхэж байна. Файрберд менежмент” хөрөнгө оруулалтын сангийн менежер Жеймс Пассин “Манай сан Монголын компаниудад хөрөнгө оруулж менежментийг нь хийж ашиг олох бүрэн боломжтой” гэдгийг онцолжээ.

УУЛ УУРХАЙ

Манай улсын нийт экспортын 90 гаруй хувийг уул уурхайн бүтээгдэхүүн эзэлж байна. Тодруулбал, өнгөрөгч сарын байдлаар нийт экспортын 44.6 хувийг нүүрс, 19.2 хувийг зэсийн баяжмал, 12.1

хувийг төмрийн хүдэр дангаар эзэлжээ. Эндээс харахад дэлхийн зах зээл дээр сүүлийн үед үнэ нь огцом уруудаж буй гурван төрлийн ашигт малтмал манай экспортын гол орлогыг бүрдүүлж буй юм. Тухайлбал, төмрийн хүдрийн үнэ гэхэд л 2009 оны түвшинд хүртлээ уначихаад байгаа. Тэгвэл өнгөрсөн наймдугаар сард нэг тонн нь 9.839.50 ам.доллар хүртэл өсч байсан зэсийн үнэ Лондоны металлын биржид 275.50 ам.доллараар буюу 3.3 хувиар буурч нэг тонн нь 8.024.50 ам.доллараар арилжаалагдсан байна.

Коксжих нүүрсний үнэ ч дэлхийн зах зээл дээр уруудсаар.

**ТӨСӨВ**

Энэ онд улсын хэмжээнд 3400 тендер зарлагдахаас 2749 нь зарлагдаж, 2100 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулжээ. Тендер шалгаруулалтыг дүгнэж, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг нь эхлүүлсэн байх үүрэг, даалгаврын биелэлт 62 хувьтай байгаа аж. Энэ оны төлөвлөгөөнд багтсан арга хэмжээг хугацаа алдалгүй бүрэн хэрэгжүүлэхэд

анхаарч, тендер шалгаруулалт яаралтай явуулах шаардлагатай байгааг Сангийн сайд Ч.Улаан Засгийн газрын хуралдаанд танилцууллаа.

ЕВРОП

Европын бүсийн 17 орны ажилгүйдлийн түвшин долдугаар сард 18 саяд хүрч рекорд тогтоолоо гэж Европын холбооны статистикийн албанаас мэдэгдлээ. Нийт ажилгүйчүүд 88 мянган хүнээр хүрээгээ тэлсэн ч зургадугаар сарын байдлаар ажилгүйчүүдийн 11.3 хувийн түвшинд өөрчлөлт ороогүй аж. Анх 1995 оноос эхэлж тооцож эхэлсэн энэхүү ажилгүйчүүдийн түвшин өнөөдөр 18.002.000 хүрч, рекорд тогтоож байна. Европын бүсэд ажилгүйдлийн түвшин Испани улсад хамгийн өндөр буюу 25.1 хувийг эзэлж байна. Хамгийн бага ажилгүйдлийн түвшинтэй оронд Австри улс 4.5 хувиар орж байна. Өнгөрсөн жилтэй харьцуулахад Европын бүсийн 10 оронд ажилгүйдлийн түвшин буурч, 16 улсад харин нэмэгджээ. Словенид энэхүү дүн өөрчлөгдөөгүй байна. Эстони улсад 13.2 хувиас 10.1 хувь, Литвад 15.2-оос 13 хувь, Латвид харин 17 хувиас 15.9 хувь болж тус бүр буурчээ. Ажилгүйдлийн түвшин хамгийн их нэмэгдсэн орнуудаар Греци (16.8-аас 23.1 хувь), Испани (21.7-оос 25.1 хувь), Кипр (7.7-оос 10.9 хувь болсон)

гурав толгой цохиж байна. Өр болон банкны хямралд орсон Испани, Грек орнуудын ажилгүйчүүдийн 50-иас дээш хувийг 25-аас доош насны залуучууд эзэлж байна.

ХЯТАД



Хятад улс Европын томоохон онгоц үйлдвэрлэгч “Аэробус”-аас 50 онгоц худалдаж авах гэрээнд гарын үсэг зурлаа. Энэхүү хэлэлцээрийг ХБНГУ-ын канцлер Ангела Меркелийн тус улсад

хийсэн хоёр хоногийн албан айлчлалын үеэр үзэглэсэн юм. Мэдээллийн “Синьхуа” агентлагийн мэдээлснээр, онгоцыг манай урд хөршид угсрах тухай гэрээг мөн хийжээ. Хятадын Ерөнхий сайд Вэнь Зябао нь Хятад улс Европын холбоонд оруулах хөрөнгө оруулалтаа үргэлжлүүлнэ гэж мэдэгдсэн байна. “Аэробус” дэлхийн хоёр дахь том онгоц үйлдвэрлэгч EADS-ийн охин компани юм. Тус хэлэлцээр нь Хятад, Европын холбооны хооронд эмисс буюу агаарын тээврийн ялгаруулдаг бохирдлоос үүдсэн маргаанаас хойшхи анхны ач холбогдол бүхий гэрээ аж. Энэ оны нэгдүгээр сараас эхэлж “Европын

холбооны ялгаруулалтын худалдааны төлөвлөлт” байгууллагаас агаарын тээврийн ялгаруулж байгаа нүүрстөрөгчийн татаас авч эхэлсэн билээ. Хятад болон бусад улс энэхүү тогтолцоог шударга бус гэж үзжээ.

Канцлер Меркель гадаад харилцааг сайжруулж, Европын компаниудын бизнесийг бэхжүүлэх зорилгоор Хятадад энэ жил хоёр удаа айлчилжээ. Өнгөрсөн онд Герман, Хятадын гадаад худалдаа 180 тэрбум ам.долларт хүрсэн нь таван жилийн өмнөх дүнгээс хоёр дахин өссөн болохыг харуулж байна. Хоёр орон харилцаа холбоо, эрчим хүч, эрүүл мэнд, далайн хамтын ажиллагаа гэхчлэн нийт 10 гэрээ үзэглэсэн байна.



ОНЦЛОХ

ШИГДЭХ ҮҮ, ШИНЭЧЛЭГДЭХ ҮҮ**И.ОТГОНЖАРГАЛ**

Есдүгээр сарын 1 амралтын өдөр таарсан ч бямба гаригт хичээлийн шинэ жилийн нээлтийг ёслол төгөлдөр тэмдэглэлээ. Төрийн өндөрлөгүүд ч олноороо бага, дунд, их, дээд сургуулиудын нээлтэд оролцож ач холбогдол өглөө. Ерөнхий сайд Н.Алтанхуяг гэхэд л хоёр ч дунд сургууль, 35 дугаар цэцэрлэгийн эрдмийн баярын нээлтэд зочлов. Эндээс иргэдийн бодолд шинэ Засгийн газар Монголын өрсөлдөх чадварын чөдөр тушаа болсон боловсролын салбарт нэлээд анхаарал хандуулах нь юм болов уу гэсэн найдлагын оч үсэрсэн ч байж болох. Тэгвэл иргэдийн сэтгэлд үсэрсэн очыг гал болон бадраахыг хүсэж Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн “Mongolian Economy” сэтгүүл есдүгээр сарын эхний дугаараа боловсролын салбарын хөгжилд зориулж байна.

Хичээлийн шинэ жил эхэлж, шинэ Засгийн газар бүрэлдэж буй энэ цаг үед бид дуусашгүй баялгийн охь болсон хүнээ хөгжүүлж, боловсролын салбарт эрс шинэчлэл, зөв бодлого үгүйлэгдэж буйг сануулжийнхүү сэтгүүлийнхээ бүтэн дугаарыг зориуллаа. Тэгээд ч Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын төвийн өнгөрсөн оны тайланд өнөө цагт дэд бүтэц нь авто болон төмөр зам, онгоцны буудлаар хязгаарлагдахаа больж, харин оюуны хүчийг торниулах технологи, шинжлэх ухаан, хүрээлэн буй орчин, боловсрол гэсэн зөөлөн дэд бүтэц нь улс орны өрсөлдөх чадварт чухал нөлөө үзүүлэх болж байна гэж онцолсон нь бий. Тийм ч учраас бид энэ удаа боловсролын салбарын асуудлыг цогц байдлаар хөндөхийг хичээлээ. Сүүлийн 20 гаруй жил Монголын боловсролын салбарт чанар орхигдож, мөнгө хөөсөн бизнес цэцэглэсэн нь улсын хөгжлийг урагшлуулахааргүй байгааг олон талаас нь гаргахыг оролдлоо. Ингэхдээ байгаа бэрхшээл зовлонг тоочихдоо биш, бидэнд ямар нөөц бололцоо байгаа юм, бусдын сайн жишгээс хэрхэн суралцах вэ, яг ямар асуудалд анхаарал хандуулах шаардлагатай байгааг чухалчилсан юм.

Монголын боловсролын систем нэгдсэн зөв бодлогогүй байгааг илчлэхдотод, гадаадын судалгааны байгууллагуудын материал, тоо баримт бишгүй байгаагаас гадна тус салбарт олон жил ажиллаж байгаа багш сурган хүмүүжүүлэгчид ч хатуу үгээр үнэнийг хэлэх нь бий. Чанаргүй боловсролын буруутныг олох арга зам Монголд бас л балархай. Их, дээд сургуулийн багш нарын зарим нь чанаргүй дээд мэргэжилтэн олноороо гарч байгаа нь ерөөсөө л бага, дунд сургуулийн багш нарын боловсрол мэдлэг нимгэн байгаатай холбоотой гэх. Тэгвэл “Овоо босгоогүй бол шаазгай юун дээр суух вэ” гэдэгчлэн нийгмийн хөдөлгөгч хүч болох сэхээтнүүдийг өлгийдөн, төрүүлдэг их, дээд сургуулийн босго хэт намссаныг юу гэх вэ. Эрдмийн их өргөөнөөс төрсөн зах зээлийн хэрэгцээ шаардлагыг хангахгүй дипломноос өөрцгүй залуус хөдөлмөрийн зах зээлд шунгаж орох биш, шувтарч үлдсээр

улсын хэмжээнд ажилгүйдлийн түвшин даруй 10 хувьд хүрэхэд том нөлөө үзүүлэв. Гэтэл цаана нь аж ахуйн нэгж, бизнесийн байгууллагынхан чадварлаг ажилтан авахын мөрөөсөл болж, ажлын байрны зар сонин хэвлэлээр нэг тавиад ч хүсэл нь биелэхгүй байх жишээний. Хөдөлмөрийн зах зээл чадварлаг боловсон хүчнээр ангаж цангаж байхад шинэхэн боловсон хүчнүүдийн үр чадвар ажил олгогчдын наад захын шаардлагыг хангахгүй байгаагаас туршлагатай боловсон хүчнээ булаацалдах “чимээгүй дайн” хөдөлмөрийн зах зээлд өрнөх болов.

Хониныхоо бэлчээрт яваа малчин өмнө нь өмсөх хувцас, идэх хоолтой нь хот явуулсан хүүхдээ “Сургууль нь олон юм байна, за тэгээд нэг юманд орж л таараа” хэмээн сэтгэл амар суудаг байсан бол одоо их, дээд сургуульд өрсөлдөөд, хувааргүй үлдсэн хүүхдээ “Хувийн сургуульд л битгий ороорой. Тэгснээс бүр болохгүй бол тогооч, үсчингийн дамжаанд ч болтугай сурсан нь дээр шүү хүү минь” гэж захидаг болсон гэнэ. Арга ч үгүй биз, сүүлийн 20-иод жил хаалгаа нээсэн болгонд нь хүүхдээ оруулж, ямар боловсролтой хүн болж гарах нь өөрөө мэдэх хэрэг гэж баахан мөнгө төлж сургасны эцэст дээд боловсролын диплом өвөртөлсөн дэлгүүрийн худалдагч, ресторан баарны зөөгч, үйлчлэгч бэлтгэж хашраа биз ээ. Чанаргүй боловсрол ийнхүү малчдыг хүртэл нэгийг бодож хоёрыг тунгаахад хүргэжээ. Харин гадуур олон нийтийн үг хэлийг цэгнэж байхад, Боловсрол шинжлэх ухааны сайдаар гайгүй юм хийчихээр хүн томилогдчихлоо шүү гэж олзуурхаж байгааг энд дуулгахад илүүдэхгүй болов уу. Л.Гантөмөр сайд ч гэсэн өөрөө “Би энэ албыг гуйж авсан. Би чадна гэдэгтээ итгэлтэй байна” хэмээн сонин хэвлэлээр итгэл дүүрэн ярилцлага өгч буй нь боловсролын салбарт ирэх дөрвөн жилд шинэчлэлийн салхи үлээж магадгүй нь ээ гэсэн иргэдийн сэтгэл дэх итгэлийн очыг улам бүр бадрааж байна.

Тиймээ, Гантөмөр сайд аа, таны өмнөх Парламентын үед төсвийн мөнгийг хэмнэх зорилгоор “Төрийн байгууллагын бандгар жийгийг халъя” гэсэн санал санаачилга үр дүн гаргаж, олон нийтийн зүгээс УИХ-ын гишүүнд өндөр үнэлгээ авчирч байсан. Тэр үед таны санаачилгыг дэмжсэн хүмүүс Төрийн ордныг улаан лоолиор будаж эсэргүүцсэн бол өдгөө боловсролын системийн гажгийг засаж, тус салбарын авлига, хүнд суртлыг халахаар зоригтой тэмцэхэд чинь нийгмээрээ уухайлан дэмжих нь дамжиггүй ээ. Үүний эхлэлийг “Mongolian Economy” сэтгүүл тавьж байна. Монголын чанаргүй боловсрол ирэх дөрвөн жилд балчиг намгандаа улам шигдэх үү, шинэчлэгдэх үү гэдгийг шинэ Засгийн газрын үйл хэрэг харуулах учиртай. Монголыг шавхагддаг баялаг уул уурхай биш, мэдлэгт суурилсан эдийн засаг, шавхагдашгүй баялгийн охь болсон оюунлаг иргэд хөгжүүлнэ. ■



Фотог Б.Бямба-Очир

БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

БООМИЛОГДСОН БОЛОВСРОЛ

...Кембриж систем гээч Монголын боловсролын салбарыг гэнэт л өөрчилж, дэлхийн хэмжээнд аваачиж, аварчих юм бодож суугаа бол том эндүүрэл болох байх. Харин багш шавийн нандин холбоо, хамтрах, бие биенийхээ оюуны өдөөгч байх замыг засаж, өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлсэн нь зөв болох болов уу...

Х.БӨРТЭ

Монголын боловсрол системийн хувьд кембриж, америк, япон, хятад, орос гэх олон бодлогын дунд төөрчихөөд, будилж явна. 1980-аад

онд Монголын боловсролын салбарыг удирдагчид “Орос школь бол бидний даган мөрдөх ёстой зүйл. Тиймээс хичээлийн бүх программ Оросын

хуулбар байх ёстой” хэмээн сургаж, хүмүүжүүлж ирсэн. Харин 1990-2000 оны хооронд “Монгол хүн монгол л байх ёстой. Уйгаржин бичгээрээ ▶

▸ өөд уруугүй уншиж, бичиж сурах ёстой. Орос хэлний хичээлийн цагийг багасгаж, монгол бичиг ор” хэмээн зарлигдсан. Үүний ачаар өдгөө крилл ч үгүй, уйгаржин ч үгүй хүн олон бий. 2000 оноос хойш “Япон, хятад сургалтын систем бидэнд яг тохирно. Дэлхий ертөнц даяаршиж байгаа энэ үед бид Азийн орнуудаар зайлшгүй явна. Тиймээс мэдлэг, боловсролын хажуугаар зан заншлаас нь суралц” хэмээн энэ үеийн хүүхдүүдийн сэтгэхүйг өөр тийш залсан. Гэтэл өнгөрсөн жилээс “Америк систем, кембрижийн сургалт манай боловсролын салбарт зайлшгүй байх ёстой. Үүнийг бага, дунд боловсролоос нь эхэлж, нутагшуулах хэрэгтэй” гээд зарим дунд сургуульд нэвтүүлээд эхэлчихлээ. Ерөнхий боловсролын сургалт 12 жил болж, зарим нь анги дэвшиж, зарим нь хэдэн анги алгасаад учраа ч олж амжаагүй байтал ийм систем нэвтрүүлж байгаад олон хүний толгой нь эргэж дургүүцдэг.

Монголын боловсролын салбарт өөрийн гэсэн чиг шугам, монгол хүний оюун, сэтгэхүйд тохирсон арга, баримтлах бодлого гэж байна уу. Энэ дунд ази ч үгүй, америк ч үгүй, монгол ч үгүй үлдэж байгаа хүүхэд, залуус хэчнээн байгаа бол.

Нэгдсэн бодлогын хүлээлт

Өдгөө боловсролын салбарт ажиллаж буй эрдэмтэн, багш, судлаачид хэд хэдэн тал болон хуваагдчихаад байна. Монгол хүний оюуны чадамж, сурах онцлог гэж бий. Түүнийг нь эвдэхгүй, аль нэг улсын сургалт гэх мөнгө дагуулсан төсөл хэрэгжүүлэхгүй гэсэн нэг хэсэг байхад дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх сургалт бий болгохын тулд сайн стандарт нэвтрүүлэх нь зүйтэй гэх хэсэг ч байна. Бүр аль алиныг нь хослуулаад үзэх хэрэгтэй гэх хүмүүс ч бий. Тэд өөр өөрийн сургууль, сургалтдаа тус тусын үзэл баримтлалаар хичээл орж, сурагч, оюутнуудыг төлөвшүүлж байна. Энэ нь тус салбарынхан бодлогоо тодорхой чиглэлд нэгтгэж, баримталж чадахгүй байгаагийн тод илрэл юм. Үүнийг МУИС-ийн Мэргэжлийн дидактикийн сургалт, судалгааны төвийн захирал,



Шог зургийг А.Амарсайхан

профессор Н.Оюунцэцэг “Манай боловсрол их мэргэн зорилго тавьдаг. Одоо мөрдөгдөж байгаа боловсролын тухай хуулиар маш гайхамшигтай, дэлхийн төвшинд хүрсэн зорилго дэвшүүлж байгаа ч эцсийн үр дүнг харахаар зорилгоосоо тэс өөр байдаг. Иргэнийг оюун ухаан, ёс суртахуун, бие бялдрын зохих чадвартай, хүмүүнлэг, бие даан сурах, ажиллах, амьдрах чадвартай болгон төлөвшүүлэхэд боловсролын зорилго оршино. Зорилгоо хангахад нэгдсэн бодлого баримталж чадахгүй байна. Тэгээд аргаа барахаараа их, дээд сургуулийн тоог цөөлөөд үзье гэсэн шийдэлд хүрээд байгаа болов уу” гэсэн юм. Харин энэ талаар БШУ-ны сайд Л.Гантөмөр “2012-2013 оны хичээлийн жилд “Зөв монгол хүн” бодлогын шинэчлэл хийхээр батлаад байна. Манай боловсролын тогтолцоо хүнийг хөгжүүлэхээсээ илүү шинжлэх ухааны мэдээлэл дамжуулж, цээжлүүлсэн, хөшүүн царцанги, олон нийтийн оролцоо хязгаарлагдмал шинжтэй байна. Эрдэм боловсролыг дипломын хэмжээнд сэтгэдэг залуус олон байгаа нь боловсролын салбар үнэгүйдсэний илрэл. Боловсролын тулгын гурван чулуу нь зан чанар, хандлагыг төлөвшүүлэх, мэдлэг эзэмших, чадвараа хөгжүүлэх юм. Тиймээс бодлогын шинэчлэлийн хүрээнд энэ бүх эмх, цэгцгүй асуудлыг шийдэх болно. Ирэх

дөрвөн жилд Монголын боловсролын салбар зөв суурьтай, зөв бүтэцтэй болно. Кембрижийн системийн хувьд төлөвлөгөөний дагуу үргэлжилнэ” гэлээ.

Боловсролын салбарын бодлогын тухай Монгол Улсын Их хурлын нэг бус тогтоол, стандарт байдаг. Сайд солигдох бүрт яамны бодлого шинэчлэгдэж, түүнийгээ заавал хэрэгжүүлнэ, Монголын боловсролыг дэлхийн тавцанд гаргаж, чанарыг нь сайжруулна хэмээн амладаг ч бахь байдгаараа. Энэ байдалд Л.Гантөмөр сайдыг өөрчлөлт, шинэчлэл хийж, өнөөдрийн ойлгомжгүй байдлыг цэгцлээсэй гэх хүн олон. Учир нь, Монголын боловсролын систем шинэчлэлийг шаардахаас гадна нэн тэргүүнд нэгдсэн бодлого, зорилтыг хүлээж буй. ▸



► **“Өөрийнхөө цонхоор харах боломжийг нь үлдээе”**

Монголын боловсролын салбар хүний төлөвшил, амьдрах чадвар, дадалд сургах талыг нь орхиод зөвхөн мэдээлэл өгөхөд анхаардагийг судлаачид дүгнэсэн байдаг. Тэгээд зогсохгүй бодлогын түвшинд нэг ижил программын хичээлийг сурагчдад цээжлүүлж, хуулуулж, түүгээрээ шалгалт авдаг. Тэр ч бүүхэл сурагч шалгалтын үеэр номон дээрх өгүүлбэрээс ганц нэг үг хаяж хэлбэл хичээлээ муу давтсанд тооцдог багш ч цөөнгүй байдаг нь хаацайлахын аргагүй үнэн. Энэ талаар “Их Монгол” дээд сургуулийн Монгол хэл, уран зохиолын багш, Төрийн шагналт зохиолч Дарма Батбаяр “Хүүхдийн оюун санааны ертөнцийг өөрт нь үлдээж, өөрөө сэтгэж, ертөнцийг өөрийнхөө цонхоор харах боломжийг үлдээх хэрэгтэй. Тэр тусмаа оюун санааны хувьд түүнийг чөлөөлж, юу хийж, хүсэж байгааг нь ажиглаж, хөгжүүлэх ёстой юм. Хүүхэд цэцгийг өнгөгүй зурмаар байвал дураараа л болог. Тэгэхэд манайхан ягаан дэлбээтэй, ногоон навчтай цэцэг зурсангүй гэж хүүхдийг зэмлэж, дүнгээс нь хасдаг. Өөрсдийнхөө хэвшмэл сэтгэлгээг сурагчдадаа тэр чигээр нь хэвшүүлэх гээд байгаа юм. Бүгд нэгэн ижил сэтгэхүйтэй болохгүйн тулд боловсролын системийг үндсээр нь өөрчлөх хэрэгтэй. Энэ нь боловсролын яамны асуудал биш. Багш, сурах гэж байгаа хүмүүсийн ласуудал. Голхоцрогдол нь мэдээллийг юүлүүрийн аргаар олгож байгаад хамаг учир бий юм. Хэний ч, хаанаас ч олж болох мэдээллийг

л дамжуулаад байгаа нь одоогийн сургалтын системийн муу тал. Энд би багш нь багшаасаа сонссон юмаа оюутнуудад дамжуулаад байгааг хэлж байна. Багш юүлүүр биш оюун ухааны өдөөгч байх ёстой” гэлээ.

Самбарын урд багш ярьж, сурагчид сонсох хэв маяг бол манай алтан дүрэм. Харин гаднын орнуудад багш нь сурагчдаа сонсож, асуусан асуултад нь хариулт өгөх маягаар хичээллэдэг. Энэ нь хүүхдийн оюун ухааныг задлах, авъяас чадварыг нь нээх, цаашлаад хэл ярианы хөгжилд нь сайн үр дүн авчирдаг байна.

Сургалтын аль систем бидэнд хэрэгтэй вэ

Кембриж, АНУ, монгол, шавь гэх мэт сургалтын олон системийн дунд эцэг, эх хүүхдүүд төөрчихөөд байна. Аль нь чанартай, үнэн зөв болохыг мэдэхгүй, арга ядахдаа харъяа яамны мэргэжилтнээс лавлахад нь “Би ч бас сайн хэлж мэдэхгүй шүү дээ. Хүүхдээ сайн багш бараадуулсан нь л дээр дээ. Систем энэ тэр ч яамай” гэх хариулт сонсож байх вэ.

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн боловсрол эзэмшүүлэх Кембрижийн сургалт гээчийг сонссоноос цаашгүй эцэг эх, сурагч, сурган хүмүүжүүлэгч олон. Сурган хүмүүжүүлэгчдийн дунд монгол хүний оюун сэтгэлгээ, амьдралын хэв маягт нутагшиж чадах сургалт биш гэж гоочлох нэг нь байхад дэлхийн боловсролтой хөл нийлүүлэх шат бол Кембрижийн систем гэж сайшаах нэгэн ч байна. Боловсролын салбарынхан өөрсдөө шилдэг сайн гэж ихээхэн хөрөнгө мөнгө зарж Монголд нутагшуулахаар

зорьж буй Кембрижийн боловсролын талаар ийм зөрүүтэй ойлголттой байхад эцэг эхчүүд, сурагчдын хувьд алиныг нь гэхээ мэдэхгүй толгой эргэх нь зүйн хэрэг. Тэгвэл асуудал хариуцсан албаны хүн ямар хариулт өгөхийг сонирхоё. Энэ талаар БШУЯ-ны Ерөнхий боловсролын газрын дарга Д.Эрдэнэчимэг “Одоо хэрэгжүүлж байгаа шинэчлэл бол өнгөрсөн 20 жилийн турш эрэл хайгуул хийж, туршсаны үр дүн. Ямар нэг туршилтын тухай ойлголт энд байхгүй. Илүү ойлгомжтой, оновчтой болгох, хүмүүст наалдацтай хэрэгцээтэй боловсролыг бий болгох чиглэл рүү л явж байгаа. Энэ бодлогыг яаж хэрэгжүүлэх, ямар хүрээг хамрах вэ, хэдэн онд хаана хүрэх вэ гэдэг чиг баримжаа ч бүгд тодорхой. Бидний төлөвлөснөөр 2015 он гэхэд бүх бэлтгэл ажил дуусна. 2015 оноос үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх ажил хийгдэнэ. 2017 он гэхэд манай улсын ерөнхий боловсролын систем бүхэлдээ олон улсын жишигт нийцсэн хөтөлбөртэй болно. Аль нэг газрын үеэ элээсэн сургалтыг ямарч судалгаа шинжилгээгүйгээр авчраад шахаад байгаа хэрэг огт биш юм. Энэ бол Монголын боловсрол дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх асуудал” гэлээ.

Дэлхийд хүлээн зөвшөөрөгдөх боловсролыг ерөнхий боловсролын сургуулиас олгож эхлэх гэж байгаа нь сайшаалтай хэрэг. Гэхдээ сайныг саар тал үргэлж дагадаг. Монголын томоохон эрдэмтэн, судлаачдын төлөөлөл “Кембрижийн систем гэж огт байхгүй. Ийм зүйлээр хүмүүсийн толгойг битгий угаа. Боловсролын салбар цаг үеэ даган хөгждөгөөрөө л хөгжинө” хэмээн ярилцаж байхыг ►

Боловсролын салбарын зардал, оны үнээр

Үзүүлэлт	2008	2009	2010	2011
Улсын нэгдсэн төсвийн нийт зардал, /сая.төг/	2466774.4	2336629.7	3080685.1	4792030.9
Боловсролын зардал /сая.төг/	414243.6	430533.9	523949.6	636720.3
Улсын нэгдсэн төсвийн зардалд боловсролын зардлын эзлэх хувь	16.8	18.5	17	13.3
Нэг хүнд ногдох боловсролын зардал /мян.төг/	156.7	160	1803	228.5

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

▶ нэг бус сонссон. Мөн энэхүү АНУ-ын дунд боловсролын систем нь өөрийн улсдаа хоцрогдсонд тооцогдож, багш, сурагчид шинэчлэл шаардаж эхэлсэн тухай мэдээлэл гаднын хэвлэлүүдэд байна.

Гэхдээ Кембриж систем гээч Монголын боловсролын салбарыг гэнэт л өөрчилж, дэлхийн хэмжээнд аваачиж, аварчих юм бодож суугаа бол том эндүүрэл. Харин багш шавийн нандин холбоо, хамтрах, бие биенийхээ оюуны өдөөгч байх замыг засаж, өөрчлөлтийг өөрсдөөсөө эхэлсэн нь зөв болов уу.

Кембриж тэгээд бусад нь. Өнөөгийн манай ерөнхий боловсролын сургалтын систем дээрх байдлаар хоёр хэсэгт хуваагдаад буй. Энэ талаар “Олонлог” сургуулийн захирал Д.Баяржаргал “Манайх шиг цөөн хүн амтай орны хувьд боловсролын салбарт баримтлах бодлого өвөрмөц онцлогтой байх ёстой. Олон сая хүн амтай улс орнууд нийтэд зориулсан сургалт явуулдаг бол бид монгол хүн бүрийг өндөр боловсролтой болгоход анхаарах ёстой. Гэтэл гаднын боловсролын систем нэртэй төслийг автоматаар хэрэгжүүлэх гэж зүтгэж байгаа нь энэ салбар уналтад орох үндэс ч болж мэднэ. Олон жил хэрэглэж ирсэн өргөн агуулга бүхий стандартыг хасах, тэр чигт нь өөрчлөх бодлого хамгийн буруу. Япон, Америк, Хятад сургалттай хувийн сургуулийн тоо олон болсон. Үүний дүнд монгол хэл, соёлоо мэдэхгүй, уламжлал, зан үйлээ ойлгохгүй хүүхэд, залуус төрж байна. Уг нь бол хүүхдийн бага нас, бага, дунд боловсрол өөрийн орны хэл, соёлыг судлахад зарцуулагдаж байвал Монголд хэрэгтэй” гэсэн юм.

Бодлогоо тодорхойл

Энэ салбарын бодлогод засаж залруулах зүйл цөөнгүйг энгийн иргэд ч эрдэмтэн судлаачид ч хэлдэг. Тухайлбал, Засгийн газрын мөрийн хөтөлбөрт

“Дээд боловсролын чанар, өрсөлдөх чадварыг дээшлүүлнэ. Дээд боловсролын сургалтын стандарт, түүгээр сургуулиудад тавих шаардлагыг олон улсын жишигт нийцүүлж боловсронгуй болгон, сургуулиудыг аттестатчилж, өрсөлдөх чадвартай цөөн сургуультай болж, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр төрөөс дэмжинэ” гэсэн заалт орсон байдаг. Энэ нь байж болох л асуудал. Гэхдээ чанаржуулж, сайжруулах асуудлыг чухалчлахын оронд боловсролын салбар бүтэц бүрэлдэхүүнээрээ тоо цөөлөх төдийхний тухай яриад сууж байгаа нь ахиц дэвшил мөддөө гарахгүйн шинж болов уу.

Энд дурдахгүй өнгөрч болохгүй нэг зүйл бол дунд сургуулийн сургалтаас уран зохиолын хичээлийг хасах тухай саналыг зарим эрдэмтэн, багш нар дэвшүүлээд байгаа нь хачирхалтай мэдээ. Энэ мэтчилэн сургалтын чанар, тавьсан зорилтоо биелүүлэхгүй мөртлөө байгаагаа үгүй хийх, тэр тусмаа хүн болж төлөвшихөд хамгийн чухал хичээлийг хасах тухай ярьж байгаа нь харамсалтай.

Бодлогоо сайжруулъя, засаж, залруулъя гэхээр төсөв, мөнгө хүрдэггүй тухай сургуулийн захирал, багш, ажилчид ярьдаг. Зах зээлийн энэ нийгэмд мөнгө бүхнийг хөдөлгөгч хүч. Энэ ч утгаараа боловсролын салбарт хангалттай төсөв байх шаардлагатай. Жишээ дурдъя. Нагоягийн Их сургууль бол жилийн төсвөөрөө Японы Токио, Киотогийн их сургуулиудтай зүйрлэхээргүй жижиг. Тус сургуулийн жилийн төсөв нэг тэрбум ам.доллар. Түүний долоон хувийг оюутнуудын сургалтын төлбөр бүрдүүлдэг. Гэтэл манай МУИС-ийн жилийн төсөв 17 сая ам.доллар. Түүний 92 хувь нь зөвхөн сургалтын төлбөрөөс ордог. Ийм болохоор сургуулиудын удирдлагуудад яамны зүгээс хатуу хандах зүрх байхгүй гэсэн үг. Шинэ сайд боловсролын салбарт шинэ салхи татуулж, сэтгэл ханамжтай, зөв боловсрол иргэдэд түгээхэд хувьсгал хийнэ гэж найднам. ■

ТУСГАЙ ХЭРЭГЦЭЭТ БОЛОВСРОЛ

ОРХИГДОГСОД

“Бид хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн өөрсдийн хүчээр амьдралаа босгох. Цаашлаад улс эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой. Гэтэл ажил олддоггүй. Бидэнд жирийн хүмүүс итгэдэггүй”.

Э.ЗОРИГТ

Хүн бол нийгмийн амьтан. Нийгэмшиж байж л хүн төрөлхтөн адгууснаас ялгарч чадсан гэдэг. Түүнчлэн хүн нийгмийн харилцаанд

орж нийгэмшиж байж л өөрийн гэсэн байр суурьтай бие хүн болон төлөвшиж чаддаг аж. Тэгвэл хүнийг хөгжүүлэх, нийгэмшихэд хамгийн чухал гурван

хүчин зүйл байдаг аж. Үүнд, үг+бодол буюу сэтгэхүй+боловсрол гэж тодорхойлогддог байна. Энэ гаргалгаа нь бүх хүний хувьд адилхан байдаг аж. ▶



Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 29 дүгээр тусгай дунд сургуулийн нэгдүгээр анги

Фотог зохиогч

Гэхдээ ихэнх хөгжлийн бэрхшээлтэй иргэд өөрсдөө нийгэмших боломжгүй учир тэднийг боловсрол олгох замаар нийгэмшүүлдэг байна. Тэгвэл Монголын хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд боловсрол олгох тогтолцоо өнөөдөр ямар байгаа бол гэдэгт манай сэтгүүл анхаарал хандууллаа. Сонин хэвлэлээр боловсролын асуудлыг байнга бичдэг ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролд анхаарал хандуулах нь ховор.

Бодол бий болгогчдын үг

Төсөөллийнхөө орон зайнд хийсвэрээр харахыг бодол гэж нэрлэдэг аж. Бодол байж гэмээнэ хүн мөрөөдөж, түүндээ хүрэхийн төлөө зорьж, зорьсныхоо үр дүнд хөдөлмөрлөж хөгжлийг бий болгодог. Тэгвэл бодол хаанаас үүсдэг вэ. Бодол үүсгэгч гол хүчин зүйл бол бидний өдөр тутам харилцаандаа хэрэглэдэг үг аж. Тухайлбал, бид талх гэх үгийг тархиндаа бодохын сацуу зууван, дөрвөлжин бөөрөнхий, зүссэн зүсээгүй гээд гурилаар хийсэн хүнсний бүтээгдэхүүн тархин

дотор дүрслэгдэнэ. Тэгвэл үг хэлж мэдэхгүй, сонсож чадахгүй хүүхэд аливаа зүйлийг төсөөлдөг ч ухамсарт түвшинд бодол гэгч байдаггүй аж. Нар мандахыг харавч нар хэмээн сэтгэхгүй, ээжийгээ харавч ээж хэмээн мэдэхгүй нэргүй, баримжаагүй төсөөлөл тэдний тархин дотор явагддаг. Үг байхгүй бол бодол байхгүй. Бодож чадахгүй бол боловсорч чадахгүй гэсэн үг. Харин эдгээр хүүхдүүдийг хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 29 дүгээр дунд сургууль үг+бодол, сэтгэхүй+боловсрол олгох замаар нийгэмшүүлдэг. Энэ төрлийн мэдлэг олгох үйл явцыг тусгай хэрэгцээт боловсрол хэмээн нэрлэдэг аж. Тус сургуульд 29 дэх жилдээ ажиллаж байгаа ахмад багш Ё.Оюундарь “Хэлний болон сонсголын бэрхшээлтэй ихэнх хүүхдүүд ямар ч үг мэдэхгүй учраас юу ч ойлгодоггүй. Тиймээс бид эхлээд хүүхдүүддээ үг зааж өгдөг. Тухайлбал, аав гэдэг үгийг мэдэхгүй хүүхдэд аавынх нь зургийг харуулаад тэгээд “А” авиа зааж өгөөд түүнийхээ дараа бүтэн үгээр нь тухайн хүүхдийн тархинд аав гэх үгийг суулгаж өгнө. Тэгээд

дараа нь уншуулж сургана” гэв. Уг сургах үйл явцыг мэргэжлийн багш нар согог засал гэж хэлдэг. Яг үүнтэй адил хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг нийгэмшүүлэх боловсролын тогтолцоонд засах гажиг согог бишгүй байгааг холбогдох хүмүүс хэлж байна.

Боловсролын системийн эхний гажиг буюу сурах бичиггүй сургалт 29 дүгээр дунд сургуульд явагддаг. Тус сургуулийн сургалтын менежер М.Бурмаа “Тусгай сургуульд тусгай л сурах бичиг хэрэгтэй. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд жирийн сургалттай сургуулийн стандарт бүхий номоор хичээл заана гэдэг байж боломгүй асуудал. Тиймээс манай сургуулийн багш нар 2008-2009 оны хичээлийн жилд сонсголын болон хэл ярианы бэрхшээлтэй хүүхдүүдэд зориулсан тавдугаар ангийн хэл бичгийн номын эх загварыг бэлдээд БСШУЯ-нд хүргүүлсэн боловч өнөөдрийг хүртэл бидний гар дээр сурах бичиг ирээгүй байна.” гэв. Харин энэ талаар холбогдох албаныхан хэлэхдээ хэдийгээр тус сургуулийн багш нарын бичсэн ном мэргэжлийн

▶ талдаа сайн байдаг ч зарим шаардлагыг хангахгүй тохиолдол байдаг гэж байсан. Түүнчлэн 2010-2011 оны хичээлийн жилээс тусгай сургуулиудад сурах бичгээ өөрсдөө хэвлэх техникийн бүх боломжийг бүрдүүлж 43.5 сая төгрөгийн хэвлэлийн иж бүрэн цех нийлүүлсэн тухай БСШУЯ-ны мэдээлэл байна. Харин 29 дүгээр сургуулийн багш нар хуучин сонголын аппараттай, хэвлэх үйлдвэр бүү хэл, сурах бичиггүй шахуу ажиллаж байгаадаа гомдоллож байв. Мөн 116 дугаар сургууль дэргэдээ хэвлэх үйлдвэртэй ч сурах бичиг үйлдвэрлэж чадахгүй байгаа аж. Учир нь, боловсролын яамнаас хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан сургалтын ерөнхий зарчмыг нарийн тусгасан хууль эрх зүйн орчин бүрхэг байгаагаас үүдэлтэй гэнэ. Одоогоор тус сургуулийн багш нар өөрсдөө сургалтын хөтөлбөрөө зохиож, түүндээ тохирсон гарын авлага хэвлэн хэрэглэж байна. Энэ талаар БШУЯ-ны мэрэгжилтэн Л.Отгонсүрэнгээс тодруулахад “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд бүр хоорондоо бэрхшээлийн ялгаа, гэр бүлийн байдал эрүүл мэндээс шалтгаалан өөр өөрийн гэсэн онцлогтой байдаг. Тиймээс нэг төрлийн сурах бичгийг олноор хэвлэх нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн онцлогт тэр бүр таарах нь ховор. Ийм учраас яг ийм сургалтын систем байна гэж заах нь учир дутагдалтай” гэв. Үүнтэй холбоотойгоор хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг маш нарийн оношлогоонд хамруулах ажил орхигдож байгааг Л.Отгонсүрэн мөн хэлсэн юм. Хэрвээ хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тархины хүлээн авах чадамж, хөдөлмөрийн бүтээмжийг нарийн судалж, түүндээ тохирсон анги нээвэл сургалтын тогтсон систем бий болгож болох аж.

Тэтгэвэртээ гарч чадахгүй байна

Багшийн эрдэм шавьд гэдэг. Гэтэл хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд эрдэм заах багш нар сүүлийн жилүүдэд ховордож байгаа аж. Өмнө нь Орос, Унгар зэрэг оронд энэ талын багш нарыг 5-6 жил сургадаг байсан

бол өдгөө тэр тогтолцоо алдагдаад удаж байна. Тухайлбал, 2005-2010 оны байдлаар ердөө хоёрхон оюутан согог зүйч мэргэжлээр Унгар улсад төгссөн байна. Түүнчлэн Монгол Улсын хэмжээнд энэ талын сургалт огт байдаггүй аж. Үүнээс шалтгаалж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сургуульд багшилж байгаа зарим багш тэтгэвэртээ гарч чаддаггүй гэнэ. Харин энэ тал дээр боловсролын яамны мэрэгжилтнүүд ихээхэн санаа зовж байгаа гэдгийг ч нуугаагүй. Тиймээс ирэх жилүүдэд төрийн зардлаар гаднын их, дээд сургуулиудад тусгай хэрэгцээт боловсрол, согог зүйчийн мэргэжлээр оюутан суралцуулах чиглэлийг нэн тэргүүнд тавьж ажиллах аж. Энэ талын асуудлыг “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулан сургах хөтөлбөр II”-т тусгаад байгаа тухай хэллээ.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг боловсруулах хамгийн том зорилго бол тэднийг нийгэмшүүлэх буюу нийгэмд өөрийн гэсэн байр суурийг нь олоход туслах явдал. Гэтэл дунд сургууль төгссөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ихэнх нь их, дээд сургуульд орж чаддаггүй. Үнэхээр сайн сурлагатай, мятрашгүй тэмцэгч зарим нь их, дээд сургуульд ороод сургуулиа амжилттай дүүрэгсэн ч ажлын байр олддоггүй байна. 116 дугаар сургуулийн дуу хөгжмийн багш Б.Батболд “Би өөрөө 116 дугаар сургуулийг төгссөн. Энэ сургуулийнхаа буянд өөртөө итгэх итгэл нэмэгдсэн. Одоо ч сургуулийнхаа буянд сайхан амьдарч байна. Гэхдээ надтай хамт сургууль төгсөж, амьдралын далайд хөл тавьсан олон найзын минь хүсэл тэмүүлэл унтарсан. Бид хэдийгээр хөгжлийн бэрхшээлтэй ч гэсэн өөрсдийн хүчээр амьдралаа босгох. Цаашлаад улс эх орныхоо хөгжилд хувь нэмрээ оруулах зорилготой. Гэтэл ажил олддоггүй. Бидэнд жирийн хүмүүс итгэдэггүй” гэсэн юм. Гаднын орнуудын туршлагаас харахад аливаа байгууллага нийгмийн хариуцлагаа ухамсарлах үүднээс тодорхой тооны хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг ажлын байраар хангадаг. Түүнчлэн тэд автобус унаагаар зорчих, сурч боловсрох, дэлгүүр хоршоо хэсэх,

өндөр дээд албан тушаал хаших зэрэг хүн л болсон хойно эрүүл хүнээс дутахгүй адил тэгш эрхтэй байдаг. Харин манайд энэ тогтолцоо байхгүй. Хүн төвтэй хүнлэг энэрэнгүй ардчилсан нийгэм гэсэн хэрнээ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг орхигдуулдаг. Тэр ч бүү хэл, мэргэжлийн сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан хөдөлмөрийн бүрэн чадамжтай иргэдийг ч ямар нэг албан байгууллага ажилд авдаггүй гэдгийг 29 дүгээр сургуулийн сургалтын менежер М.Бурмаа учирлаж байсан юм.


Дээрх мэт тусгай хэрэгцээт боловсрол буюу хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын салбарыг төр, засаг анхаарч үздэггүй гэх гомдол олон бий. Харин ИЗНН хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн асуудлыг хариуцдаг нэгж Засгийн газарт заавал байх ёстой гэж үзэж байгаа нь тэмдэглэх ёстой болов уу. ИЗНН-ын дарга С.Оюун хэвлэлд өгсөн ярилцлагадаа “Шадар сайд юм уу, эсвэл Ерөнхий сайдын дор хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хариуцдаг ажлын алба байвал болно. Бүрэлдэхүүн нь цөөхөн байж болно шүү дээ. Гаднын оронд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн комисс, агентлаг хүртэл байдаг. Манайд үүнийг хариуцсан алба байх ёстой. Тиймээс энгийн боловч маш чухал асуудлаар Засгийн газарт саналаа хүргүүлэхээр бэлдсэн” гэжээ. Түүнчлэн БШУЯ, ЖАЙКА-тай хамтран хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн боловсролын асуудлыг бүрэн цогцоор нь авч үзэх төсөл хэрэгжүүлж магадгүй гэх хүлээлт үүсээд байгаа аж.

Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн боловсролын асуудлын зах зухаас хөндөхөд ийм байна. Монголын ойлгомжгүй тодорхой бус чанаргүй боловсролын үйлчилгээ хөгжлийн бэрхшээлтэй битгий хэл, эрүүл саруул иргэдэд ч эрх тэгш хүрэхгүй байгаа нь олон түмнийг бухимдуулж, хэлэх үгийг нь барж буй нь нууц биш. Хатуухан хэлэхэд хөгжлийн бэрхшээлтэй гэдгээрээ нийгмээс гадуурхагдаж орхигдсон иргэдийн хувьд сайн боловсрол эзэмшиж, сайхан ажиллаж амьдрах хүсэл нь байгаа ч хясал нь хавьгүй их. ■

АВЛИГА

БОЛОВСРОЛЫН АВЛИГА БУЮУ ТҮНТГЭР ДУГТУЙ

Ачааллаа дийлэхгүй байхад юун хүүхэд нэмж авах” гээд халгаахгүй. Халгаахгүй ч гэж нүдээрээ харж байхад ялангуяа цэцэрлэгүүдийн эрхлэгч нар халгаахгүй байхаас аргагүй нөхцөл байдал өнөөдөр үүсээд буй.



Х.АНАНД

Боловсролын салбарынхны хамраа сөхөж, халаас нь түнтийдэг үе ид өрнөж байна. Хэдийгээр “Боловсролын салбар авлигаас ангид, сурагчид минь цэцэг, чихрийн цуглуулга ч битгий авчир” хэмээн намжирддаг ч тэд “Яах нь вэ дээ, хэрэггүй, яах гэж ингэж байдаг юм” гэж хэлэх дуртай. Жишээг холоос бус өөрөөсөө авъя. Өөрийн хүүхдээс гадна хамаатан садны нийлсэн дөрвөн хүүхэд цэцэрлэгт, гурван хүүхэд дунд сургуулийн нэгдүгээр

ангид, мөн тооны хүүхэд энэ жил их, дээд сургуульд элсэж байгаа юм. Хүүхэд бүр авлига өгч байж цэцэрлэг, сургуульдаа арай чамай орлоо. Эцэг, эхчүүд боловсрол, эрүүл мэндийн салбарынхныг авлигачид гэдэг ч өөрсдөө өгсөөр, өгөхөөс өөр аргагүй байдалд хүрсээр байна.

Сургуулийн өмнөх боловсрол дахь авлига

Намрын намарт л эцэг, эхчүүд “Хүүхдээ цэцэрлэгт оруулах гэтэл бүртгэл нь дуусчихаж” хэмээн танил тал, ар, өврийн хаалга хэрэглэхээр хүний эрэлд хатдаг. Энэ жил “Хүүхэд цэцэрлэгт оруулж өгнө. Хүссэн сургуульд нь зуучилж өгнө. Сайн багшид шавь оруулна” гэх мэтийн зар зарын сонин, цахим хуудсуудаар дүүрсэн нь энэ салбарт авлига цэцэглэн хөгжиж, оргил үедээ ирсэнийг олон баримтгүй гэрчилнэ. Багш нарыг авлигаас ангид байх ▶

► сургалтад хамруулж, эрхлэгч нарт авлига авахгүй байх мэдэгдэл хүргүүлээд ч тусыг эс олж байна.

Хүүхдээ цэцэрлэгт оруулахын тулд хичээлийн эрхлэгч, ангийн багш, арга зүйч гээд холбоотой бүгдийнх нь гарт хэдэн төгрөг атгуулах ёстой. Үгүй бол “Хүүхдийн тоо гүйцсэн. Нэмж хүүхэд бүртгэхгүй. Ачааллаа дийлэхгүй байхад юун хүүхэд нэмж авах” гээд халгаахгүй. Халгаахгүй ч гэж нүдээрээ харж байхад ялангуяа цэцэрлэгүүдийн эрхлэгч нар халгаахгүй байхаас аргагүй нөхцөл байдал өнөөдөр үүсээд буй. Миний олж сонссоноор олон улсын жишигт цэцэрлэгт нэг ангид дээд хязгаар нь 25 хүүхэд байх ёстой гэсэн. Гэтэл манайд энэ тоо 2-3 дахин өссөн. Захын хорооллуудын зарим цэцэрлэгийн бага бүлэг нь 50-60 хүүхэдтэй байна гээд бод доо. Үнэхээр нөхцөл байдал нь ийм байхад цэцэрлэгийн эрхлэгч нар халгаахгүй байх нь ч аргагүй. Гэвч монголчуудын танил тал, ар өврийн хаалгадга уламжлал нь улсын цэцэрлэгт хамрагдсан багачуудын идэх хоол, амьсгалах агаарыг давчдуулж байна. Ийнхүү нэг нь цэцэрлэгт хүүхдээ өгч, нөгөө нь хүүхдийг нь авч байгаа нэртэй авлигыг цэцэглүүлэх нь хэл мэдэхгүй хүүхэд багачууд, багш сурган хүмүүжүүлэгчдийг зовоож, амийг нь тэмцүүлж байна, Боловсрол, шинжлэх ухааны сайд аа! Цэцэрлэгийн бага бүлгийн нэг ангид бараг 60-аад хүүхэд байж таарах уу. Тэнд чинь эхийнхээ мөөмнөөс гараагүй шахуу амар тайван орчинг чухалчилж байх учиртай доод тал нь ой найман сартай, дээд тал нь хоёр ой гаруйтай хэл мэдэхгүй, ухаан суугаагүй бяцхан амьтад бий шүү дээ. Сайд та ялангуяа Улаанбаатар хотод цэцэрлэгийн тоог нэн яаралтай нэмэгдүүлэхэд анхаарахгүй бол бяцхан үрс, сурган хүмүүжүүлэгчдийн аль аль нь сөхрөх нь ээ.

Тэрбитгий хэл, есдүгээр сарын 3-нд нийслэлийн СХД-ийн 26 дугаар цэцэрлэг хашаандаа гэр бариад ахлах ангийн хүүхдүүдээ авч байв. Гэр цэцэрлэгийг уг нь хөдөө, орон нутагт ажиллуулдаг гэж бодсон чинь XXI зуунд Улаанбаатар хот нийслэлдээ гэр цэцэрлэг ажиллуулж байгаа нь хөгжлөөс ухарсан хэрэг биш үү.

За үндсэн сэдэв рүүгээ эргэн орёе. Ингээд нэг юм цэцэрлэгт бүртгүүлчихлээ гэхэд “Хүүхдэд минь анхаарал сайн тавиарай” гэсэн тусдаа хөлс багшид нь өгөхгүй бол болохгүйг эцэг эхчүүд сайн мэднэ. Хүүхдэд нь ор олдохгүй. Үүдний голдуу, үймүүлж, сахилгагүйтдэг багачуудтай нэг ширээнд суулгачихаж мэднэ. Цаашилбал бусдад зодуулж байсан ч тоохгүй байх магадлал өндөр. Энэ мэт болгоомжлол, эцэг эхчүүдийн зовнилоор услагдан авлигыг улам цэцэглүүлж байна. Улсын цэцэрлэгт орж буй хүүхдийн эцэг, эхчүүдийн халааснаас энэ намрын байдлаар хамгийн багадаа 50-100 мянган төгрөг авлигад очиж байна. Энэ нь багш, эрхлэгч нар нь авлига авах дуртайдаа биш, хотын хүн амын нягтаршил, төвлөрлөөс үүдэн нийслэлд цэцэрлэгийн хүрэлцээ хангамж хомс байгаа нь эцэг эхийг дугтуй барьж гүйлгэхэд хүргэж буй хэрэг. Энэ зөвхөн БШУ-ны сайдын хэрэг биш, ард түмний өмнө үр хүүхдийг чинь эрүүл ая тухтай өсөж, сурч боловсрох орчин нөхцөлийг бүрдүүлэхийн төлөө ажиллана гэж сайхан амлаж гарч ирсэн УИХ-ын гишүүдийн бас анхаарал хандуулах ёстой ажил байлтай.

Дунд сургуулийн өглөг

Монголын 0-6 насны нийт хүүхдийн 63 хувь нь сургуулийн өмнөх боловсрол эзэмшиж чаддаг гэх судалгаа байна. Үлдсэн нь гэртээ, эмээ өвөө дээрээ, хажуу айлдаа хүмүүждэг гэсэн үг. Харин дунд сургуульд бол гэртээ үлдэх гэсэн ойлголт байхгүй. Нас нь болов уу, үгүй юу бүгдийг нь сургуульд оруулдаг. Үүнд бас авлига хэрэгтэй. Орчин цагт эцэг, эхчүүд хүүхдийнхээ боловсрол мэдлэгт юу юунаас илүү анхаарч, шаардлагатай бүх авлигыг өгдөг болсон. “А үсэг заасан багш нь сайн байвал цаашдаа биеэ даачихдаг юм” гэх ойлголт нийтлэг. Үүнтэй холбоотойгоор эцэг, эхчүүд сайн багшийн эрэлд гардаг. Найз нөхөд, хол ойрын хүнээс дуулсан “Чанга, сайн” гэсэн багшид хүүхдээ өгөх гэж хичээдэг. Энд мэдээж эрж хайж олсон багшдаа гарыг нь цайлгаж, үр хүүхдээ даатгахгүй бол алдас болно.

Цаашлаад баяр бүрээр багшийгаа баярлуулах гэж хүүхэд, эцэг, эхгүй шамдацгаана. Сурагчид хоорондоо “Хэн хамгийн их А өгч багшийг баярлуулах вэ” гэж хүртэл уралддаг тухай баримт байдаг. А гэдэг нь онц дүнгийн үнэлгээ бус авлига юм. Үүнээс гадна төгсөх шалгалт бол багш нарын байнга баярлах хэдэн өдөр. Үүний дээр хонхны баяр нэмэгдэнэ. 1990-ээд онд хонхны баяр чихрийн цуглуулга, жаазтай зураг, хивс зэргээр үнэлэгддэг байсан бол өдгөө нөүтбүүк, машин, бараг л орон сууцаар хэмжигдэх нь холгүй байна. Гар утас, зурагт, угаалгын машин, үнэт эдлэл бол хонхны баярт улиг болж, үеэ өнгөрөөсөн зүйл. Хүн бүр хүүхдээ дунд сургууль төгсгөж үзсэн болохоор өөр баримт дурдах нь илүүц биз ээ.

Түүнчлэн гадаадын их, дээд сургуульд тэтгэлэгтэй болон улсын зардлаар суралцахыг хүсэгч, суралцагсдын дундах авлига төгрөгөөр бус валютаар хэмжигддэгийг харъяа яамны мэргэжилтэн цухуйлгаж байсан.

Дээд боловсролын хачир

Хүүхдээ их, дээд сургуульд тэр тусмаа улсын сургуульд элсүүлнэ гэдэг эцэг, эхчүүдийн хувьд маш том даваа. Хүүхэд нь үнэхээр толгой сайтай, хүссэн сургуульдаа авах ёстой оноогоо авч чадсан бол авлигын талаар эцэг, эхчүүд нь мэдэхгүй өнгөрч болно. Харин элсэгч бүр тийм биш нь харамсалтай. Тэр дундаа орон нутагт дунд сургууль төгсөгчдөд их, дээд сургууль бол бүр ч том даваа. Орон нутагт амьдардаг эцэг, эх болгон хүүхдээ хөдөө мал маллаж, ногоо тарьж өөрсөдтэйгээ адил амьдралаар амьдруулахгүйн тулд хот бараадуулж, их, дээд сургуульд оруулахыг хичээдэг. Гэвч улсын нэг сургуулиас хамгийн ихдээ найман хуваарь л орон нутагт очдог. Аймгийн хэмжээнд Ерөнхий шалгалт өгсөн 300-500 хүүхдийн ердөө 30 хувь нь л улсын сургуулийн хуваарь авч чаддаг байна. Ингэж авахдаа бас онооны бонус гэх дугтуйтай мөнгө өгөх хэрэг гардаг байна. Дугтуй зузаан байх ►

► тусам тэнцэх магадлал өндөр гэж ярих юм билээ. Шалгалтад тэнцэж, сургууль авч чадаагүй хүүхэд бүр хотод ирээд улсын сургуульд орохыг хичээнэ. Аав, ээж нь хэдэн мал, ноос, ноолуураа зараад багш нарт хахууль өгч, хүүхдээ сургуульд оруулахаар хотын зүг нүүдэллэнэ. Сүүлдээ улсын зарим их, дээд сургуулийн үүд хавиар "...ийм ангид оруулж өгнө. Тийм ангид элсүүлнэ" гэж шивнэн зогсох зуучлагчид утгах болж. Тэдний сургуульд оруулж өгөх ханш 800.000-2.5 сая төгрөг. Зарим нь бүр таван сая төгрөгт хүрдэг гэх. Хүмүүсийг хоргоон зогсож буй зуучлагчид бол тухайн сургуульд ах, эгч бүр аав, ээж нь ажилладаг, эрх мэдэл бүхий танил талтай нэгэн байдаг аж. Багш нар ийм сүлжээ байдлаар ажилладаг бөгөөд жилд 8-10 хүүхэд элсүүлэх нь энгийн үзэгдэл байдаг гэх. Их, дээд сургуулийн хаалга татсанаар авлига дуусаж байгаа юм биш. Дүн гаргах, төгсөх шалгалт гээд авлигагүй юм үгүй. Төгсөх шалгалт бол авлигыг цэцэглүүлэгч нэг том механизм. Хавар болж, шалгалт дөхөх тусам багш нарын ааш хувирч, загнаж, зэмлэх нь ихсэнэ. Дүн гаргах өдөр бүр ч хэцүү, хавьтсан ойртсон бүгдийг хяргачих гээд. Энэ үед нөгөөх дугтуй л багш нарын аашийг зөөлрүүлж, уурыг гаргана. Дүн засуулахтай холбоотой авлигын хэд хэдэн хэрэг өнгөрсөн хавар илэрч, Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургууль зэрэг нэр бүхий сургуулийн багш нар АТГ-т

шалгагдсан билээ. Арай ядан төгслөө ч авлигаас салж чадахгүй. Өгөөд сурчихсан болохоор ажилд орох анкет бөглөх, албаны даргатай нь уулзах гээд хөдлөх бүртээ л дугтуй өгөх гээд салахгүй. Нөгөөдүүл нь ч сурчихсан болохоор авах гээд горьгүй. Их, дээд сургууль төгсөгчдийн ихэнх нь ажилгүй үлддэгийн, арван хэдэн жил онц сурчихаад ажлын байргүй хоцроод байгаагийн гол учир нь авлига гэгчид байгаа юм. Улсын байгууллагад ажилд орно гэвэл мэдлэг, чадвар, туршлага хамаарахгүйгээр 2.5-5 сая төгрөгтэй байхад л хангалттай. Ганцхан дугтуй өгөөд насныхаа хоолтой амархан залгасан хүн зөндөө байна, цаана чинь.

Авлигын эсрэг бид юу хийж чадах вэ?


Энэ тухай хэн хүнгүй ярьдаг ч иргэд олонхио дагаж дуугүйхэн авлигад автсаар байдаг болохоор эрхэм авлига гуай хэзээ ч алга болохгүй, мөхөж сөнөхгүй, нийгэм ч эрүүлжихгүй. Энд авлигатай тэмцсэн нэгэн жишээ дурдъя. Нэгэн улсын сургуулийн оюутнууд Монголын өмнөө барьдаг нэр хүнд бүхий багшид шалгалт өгөх болж. Эхний хүүхдүүд өчиггүй унаад байж. Гэтэл оюутнууд дэвтрийнхээ завсар мөнгө хавчуулаад өгтөл тэнцэж эхэлжээ. Нэг оюутан мөнгөө дэвтрийнхээ завсар хавчуулж өгчихөөд, асуултдаа ч хариулж. Тэгээд дүнгээ авсныхаа

дараа "Багшаа мөнгөө авъя" гэж нөгөөх багшийг эвгүй байдалд оруулсан гэдэг. Даанч иймэрхүү эсэргүүцэл тун ховор, эгээ л өдрийн од шиг. Төр засаг, харьяа яамны удирдлагууд "Авлигыг устгана. Багш нарыг сурагчдаас цэцэг ч авдаггүй болгоно" хэмээн уриа лоозон тавьдаг ч энэ байдал амь бөхтэй оршоор, улам бүр цэцэглэсээр.

Авлигаас хэрхэн ангижрах вэ

БШУ-ны сайд Л.Гантөмөр "Ирэх дөрвөн жил бол боловсролын салбарын авилгыг үндсээр нь устгах жилүүд. Сурагчдыг багшдаа цэцэг, бэлэг сэлт өгөхгүй, өгүүлэхгүй байх хэрэгтэй. Бэлэг, цэцэг өгөөгүй хүүхэд нь "Би багшид юм өгөөгүй юм чинь надад дургүй болсон байх" гэх ойлголт авч, хичээлийн идэвх, оролцоо сулардаг нь судалгааны үндсэн дээр батлагдсан зүйл. Тиймээс багшийг авах, сурагчдыг өгөх сэтгэлгээгүй болгохыг зорих болно" гэлээ.

ШУТИС-ийн ректор, гавъяат багш, профессор Б.Дамдинсүрэн "Бөөс гэж юу байдгийг мэдэх үү? Бөөс гэдэг бол хүний биеийн дулааныг дулдуйдан "амь зуудаг", шөнө, өдөр ялгалгүй хүний мах, цуснаас шимж хооллодог, нэгэн төрлийн хилэнцэт хорхой, шавьж юм. Монголын боловсролын салбар авлига гэгч бөөсөнд бариулаад нэлээд цаг хугацааг үдлээ. Түүнээс салахад уг нь амархан. Түүгээд л хаячих юм. Гэвч нөгөөх авлигын бөөснүүд чинь хачиг, хувалз, туузан цагаан хорхой болчихоод салж өгөхгүй байна. Салгаад хаячих зоригтой хүн ч олдохгүй байна. Аалзны тор шиг сүлжилдчихсэн болохоор нэгийгээ илчилбэл хамт уначих гээд, нөгөөгөө түлхчихвэл хамаатан садан нь мултарчих гээд болохгүй байна. Аалзны торыг тэр чигт нь цэвэрлэх нэг арга бол багш нарын цалин, хөлс, хангамжийг сайжруулж, хяналт, шийтгэлийн цензурыг нарийн, өндөр тавих. Өндөр цалинтай хүн золигийн юмнаас болж, амьдралаасаа салахыг хүсэхгүй шүү дээ. Оюутнуудын хувьд тэнцэтлээ унах арга байна. Гэхдээ тэд тэгэхгүй л дээ" гэв. ■



ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХӨДӨЛМӨРИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН ПАРАДОКС

25-34 насны хүн амд эзлэх дээд боловсрол эзэмшигчдийн тоогоор Монгол Улс 15 орноос зургадугаарт эрэмбэлэгдэж буй. Оросын залуусын 25 хувь нь дээд боловсролтой байдаг бол Монголд энэ үзүүлэлт 32.7 хувьтай байна. Боловсон хүчин ийм арвин байтал аж ахуйн нэгжүүд хомсдолд ороод байгаа нь гайхал төрүүлэх аж.



Фотог Э.Зоригт

Сүүлийн 20 гаруй жил их, дээд сургуулиуд чанаргүй боловсон хүчин мөнгөөр “үйлдвэрлэсэн” нь өдгөө эдийн засагт аюулын харанга дэлдэх хэмжээнд хүрээд байна. Учир юу вэ гэвэл нийгмийн эрэлт хэрэгцээнд тулгуурлахгүйгээр бэлтгэгдэж гарсан мэдлэг боловсрол нимгэнтэй олон мянган шинэхэн мэргэжилтэн зах зээлийн эрэлт хэрэгцээг хангах биш, харин ч эсрэгээрээ ажилгүйдлийн түвшин гэрлийн хурдаар нэмэгдэхэд нөлөөлж буй нь таагүй. Үүнийг гэрчлэх баримтыг Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын судалгааны төв “Монгол Улсын өрсөлдөх чадварын тайлан-2011”-д “оюуны дайжилт” хэмээн томъёолон тусгажээ. “Оюуны дайжилт” гэж чухам юуг хэлж байна вэ гэвэл “Өнөөдөр эрдэс баялгийн салбар баян байгаа учраас бусад салбарын шилдэг боловсон хүчнийг өндөр цалингаар “урвуулах” болов. Энэ нь уул уурхайн бус салбарт ур чадварын хомсдол үүсгэж, улмаар тэдний өрсөлдөх чадварыг бууруулж байна” гэж Монголын өрсөлдөх чадварын төв үзжээ. Жил бүр олон мянгаараа гарч буй шинэхэн боловсон хүчнүүдийн ур чадвар ажил олгогчдын шаардлагыг хангахгүй байгаагаас туршлагатай боловсон хүчнээ булаацалдах “чимээгүй дайн” хөдөлмөрийн зах зээлд өрнөх болсныг ч дээрх судалгааны төвөөс өнгөрсөн тавдугаар сард “Монгол Улсын өрсөлдөх чадвар-2011” тайланг танилцуулах үеэр дуулгасан билээ. Тиймээс Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадварын төвийн тайлангийн хөдөлмөрийн зах зээлийн тухай нийтлэлийг хүргэе. ▶

► Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ 5.3 тэрбум ам.доллар буюу ДНБ-ий 62 хувьд хүрсэн тухай Дэлхийн банкны тайланд дурджээ. Монголчуудын өмнө нь хэзээ ч үзэж байгаагүй энэ их мөнгөний 85 хувь нь зөвхөн уул уурхайн салбарт шингэжээ. Эдүгээ манайд “Рио Тинто”, “Валье”, “Пийбоди Энержи” зэрэг дэлхийн уул уурхайн том компани үйл ажиллагаа явуулж байна. Зүй нь олон зуун жилийн түүхтэй эдгээр компаниас бид зөвхөн “ногоон”-ы хөрөнгө оруулалт бус, оюуны хөрөнгө оруулалт шүүрээд авах ёстой. Гэтэл байдал эсрэгээрээ эргэв. Гадаадын хөрөнгө оруулалттай уул уурхайн компаниуд бусад салбарын ажиллах хүчний “өрмийг нь хамаад” авч байна. Энэ нь дотоодын компаниудыг боловсон хүчний хомсдолд оруулж, өрсөлдөх чадварыг нь бууруулж буй хэрэг.

Өрсөлдөх чадварын тайлангийн хүрээнд авдаг Удирдах ажилтны санал асуулгын үр дүнд манайд боловсон хүчний хомсдол хэдийнэ бий болсныг илчилсэн юм. Мэдээллийн технологи, санхүүгийн чадварлаг мэргэжилтнүүдийн олдоц ховроос гадна инженерүүд болон

чадварлаг удирдах ажилтнуудыг олж ажиллуулах нь бэрхшээлтэй байдгийг хувийн хэвшлийнхэн илэрхийлжээ. Сонин телевиз, радиогоор хөврөх ажлын зарууд ч боловсон хүчний эрэлт их байгааг гэрчилнэ. Харин одоо нийлүүлэлтээ харъя.

25-34 насны хүн амд эзлэх дээд боловсрол эзэмшигчдийн тоогоор Монгол Улс 15 орноос зургадугаарт эрэмбэлэгдэж буй. Оросын залуусын 25 хувь нь дээд боловсролтой байдаг бол Монголд энэ үзүүлэлт 32.7 хувьтай байна. Боловсон хүчин ийм арвин байтал аж ахуйн нэгжүүд хомсдолд ороод байгаа нь гайхал төрүүлэх аж. Жил бүр шинэхэн диплом өвөртөлсөн 20 гаруй мянган оюутан ажилгүйчүүдийн эгнээнд элсэн ордог юм байна. 2011 онд 35,847 оюутан их, дээд сургууль төгссөнөөс ердөө 12,975 нь л ажлын байртай золгож, үлдсэн 22,872 нь буюу 64 хувь нь хоосон хоцорчээ. Их, дээд сургуулиуд ажил олгогчдын шаардлагад нийцсэн боловсон хүчин бэлтгэж өгөхгүй байгааг хувийн хэвшлийнхэн онцолж байна. Тийм ч учраас компаниуд дөнгөж төгссөн оюутныг хямд үнээр авч дадлагажуулахаас илүүтэй ажлын

туршлагатай боловсон хүчнийг өндөр цалингаар авах гэж зүтгэж, цөөн хэдэн хүнээ булаацалдаж байгаа аж.

Хувийн сургууль хэт олширч, дээд боловсролоор бизнес хийснээр “дипломтой ажилгүйчүүд”-ийг үйлдвэрлэж байна гэсэн шүүмжлэл нэлээд гардаг ч энэ нь гол шалтгаан биш юм. Өнөөдөр Монголд 101 их, дээд сургууль коллеж байгаа боловч 172,798 оюутны олонх нь буюу 104,101 нь төрийн өмчит 15 сургуульд суралцаж байгаа. Тэгвэл төрөөс боловсролд зарцуулах мөнгөний хэмжээ жилээс жилд өссөөр ирсэн атал их, дээд сургуулиудын үйлдвэрлэж буй “бүтээгдэхүүн”-ий чанар яагаад сайжрахгүй байна вэ?

“Манай сургуулийн санхүүжилтийн ердөө 6.8 хувь төсвөөс ирдэг. Үлдсэнийг нь бид оюутны төлбөрөөс л гаргаж байгаа. Гэтэл орлогын 70 хувь нь зөвхөн багш нарын цалинд явчихдаг. Сургалтын орчин, тоноглолоо сайжруулахад ямар ч хөрөнгө оруулалт хийж чадахгүй байна” гэж МУИС-ийн захирал С.Төмөр-Очир өнгөрсөн оны Монголын эдийн засгийн чуулганы үеэр тайлбарлаж байв. Тиймээс төрөөс боловсролд зарцуулж буй мөнгө хэрэгтэй зүйлдээ очиж байна уу гэдэгт хяналт тавьж, дээд боловсролын тогтолцоог эргэж харах шаардлагатай болжээ. Эдийн засаг өсөхийн хэрээр аж ахуйн нэгжүүд барилга, уул уурхайн мэргэжилтний эрэлд хатаж байна. Гэтэл оюутнуудын 70 хувь нь их, дээд сургууль, 30 хувь нь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвүүдэд суралцаж буй. Ажлын байр гэхээр яг эсрэг дүр зураг гарч ирдэг нь “дипломтой ажилгүйчүүд” нэмэгдэх бас нэг шалтгаан юм. Ийнхүү барилга уурхай дээр ажиллая гэхээр диплом хайран, мэргэжлээрээ ажил хайя гэхээр ур чадвар нь хүрдэггүй хүмүүс нийгмийн нэлээд хэсгийг бүрдүүлэх болов. Катарын нийт хүн амын 74.87 хувь нь Сингапурын 61.18 хувь нь хөдөлмөр эрхэлж байхад монголчуудын ердөө 37.18 хувь нь ажлын байртай байгаа юм.

Ажилгүйчүүдийн түвшин 2010 онд 9.9 хувьтай гарснаар манайх хөгжиж буй 15 орноос 13-дугаарт жагсчээ.

Бас нэг сонирхолтой тоо. 2011 онд ►

Дотоодын их, дээд сургууль, коллежид суралцагчид, төгсөгчдийн тоо

Мэргэжлийн чиглэл	Суралцагчид	Төгсөгчид
	2011-2012	2010-2011
Бүгд	172198	35847
Багш, боловсрол судлал, сурган хүмүүжүүлэх	22381	5775
Хүмүүнлэгийн ухаан	11176	2565
Урлагын төрөл, урлаг судлал	3631	609
Хууль, эрх зүй	8331	2280
Нийгмийн шинжлэл	13910	3396
Худалдаа, бизнесийн удирдлага	36514	8383
Нийтийн мэдээлэл, бичиг хэрэг	2295	485
Математик, компьютер	6385	1212
Үйлчилгээ	8045	2124
Байгалийн шинжлэл	5570	914
Анагаах ухаан	15973	3135
Инженер	26861	3543
Архитектур, хот төлөвлөлт	5752	635
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас агнуур	5286	791
Бусад мэргэжил	688	

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

► буюу “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих жил”-ийн хүрээнд манай хувийн хэвшлийнхэн 72 мянган монгол хүнд ажил олгоод зогсохгүй 62 мянган хятад хүн авчирч ажиллуулсан тухай Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны дэд ерөнхийлөгч Х.Ганбаатар тайлбарласан юм. Энэ жил мөн урд хөршөөс 50 гаруй мянган ажилчин “импортолно” гэсэн таамаглал гарч байхад Монгол Улсын бүртгэлтэй ажилгүй иргэдийн тоо 58.4 мянга болж, 51.6 хувиар өссөн тухай Үндэсний статистикийн хорооноос мэдээлж байна. “Тэдэнд ажил мэргэжил олгоод, хөдөлмөр эрхлэх сэтгэхүйтэй болгож чадсан бол Хятадаас ажиллах хүч авах хэрэггүй байж болохоор байгаа юм” хэмээн Х.Ганбаатар ярьж байсан.


Хөдөлмөрийн зах зээлийг төрөөс зохицуулдаг социализмын үед байдал өөр байв. “Эрдэнэт” үйлдвэрийг 1987 онд ашиглалтад орно гэж төлөвлөөд, нарийн мэргэжлийн инженер, техникийн ажилтнуудыг 1973 оноос бэлтгэж байжээ. Тэгвэл Оюутолгойн гэрээг батлах гэж долоон жил сажлах явцдаа манай эрх баригчид энэ уурхайд ажиллах боловсон хүчнээ бэлтгэх тал дээр хуруугаа ч хөдөлгөөгүй.

Хэдийгээр 2010 онд Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль батлагдаж ажил олгогчдыг мэргэжилтнээр хангах тогтолцоо бий болсон ч зах зээлийн эрэлт хэрэгцээг гүйцэхэд хэцүү юм. Зам, барилгын мэргэжилтэн одоо ч хүрэлцээгүй байгаагаас Хятадаас ирэх ажилчдын тоо улам л нэмэгдэх төлөвтэй. Засгийн газар 2016 он гэхэд Монголын авто замын сүлжээний 95 хувийг хатуу хучилттай болгоно гэсэн зорилго өвөртөлж буй. Мөн 100.000 айлын орон сууц зэрэг нүсэр ажлыг монголчууд нугалж дийлэх үү? Дэлхийн банкны хийсэн судалгаанаас үзэхэд мэргэжилтэй ажиллах хүчин Монголын нийт ажиллах хүчний ердөө 20 хувийг эзэлж байгаа нь эдүгээ уул уурхайн салбарт дайчлагдаад байна. Энэ бүхнээс үзэхэд манай хөдөлмөрийн зах зээлд төрийн анхаарал шаардлагатай байгаа юм. Эдийн засаг өсч, их бүтээн байгуулалт эхэлж байгаатай холбоотойгоор юун түрүүнд мэргэжилтэй ажиллах хүчнээ илүү эрчимтэй бэлтгэх шаардлагатай. Мөн дээд боловсролын тогтолцоог эргэн харж, их, дээд сургуулиуд тооноос чанарт шилжихэд анхаарах хэрэгтэй байна. Чили улсад их, дээд сургуулиуд ашгийн төлөө бус байдаг ч удирдах зөвлөлдөө бизнесийн төлөөллийг өргөнөөр оролцуулдаг туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ байна. Ажил олгогчидтой аль болох ойр байж гэмээнэ тэдний шаардлагыг хангахуйц мэргэжилтэн бэлтгэж чадна шүү дээ.


Мөн гадаадын хөрөнгө оруулалттай компаниуд дотоодын аж ахуйн нэгжүүдийн шилдэг боловсон хүчнийг өндөр цалингаар даллаж, “урвуулах” хандлага цаашдаа улам бүр лавзрах төлөвтэй. Харин үндэсний жижиг компаниуд ур чадвартай мэргэжилтнүүдээ уул уурхайгаас харамлалаа ч хадгалж үлдэх сачийгүйн улмаас “дипломтой ажилгүйчүүд”-ээс сонгож аваад, цаг мөнгө гарган дадлагажуулдаг “дамжлага” болох магадлалтай байна. Үүнд төр засгийн зүгээс одооноос л анхаарахгүй бол үндэсний компаниуд саажиж, хөдөлмөрийн зах зээл голланд өвчинд нэрвэгдэж мэдэх юм. Тухайлбал, гадаадын

компаниуд боловсон хүчин авах гэж байгаа бол тэднийг бэлтгэсэн компани, албан байгууллагад нь нөхөн олговор төлдөг хэлбэрийг хуульчлан зохицуулж, шинээр буй болгох боломжтойг УИХ-ын гишүүн Р.Амаржаргал бичсэн байдаг. Аливаа аж ахуйн нэгжийн хувьд хамгийн чухал баялаг нь хүний нөөц. Улс орны хөгжлийн түвшин ч иргэдийнх нь ажил эрхлэх, санаачлах чадвараас шалтгаалдаг учир хөдөлмөрийн зах зээлдээ гойд анхаарах учиртай. ■

IT буюу мэдээллийн технологийн чадварлаг мэргэжилтний хүрэлцээ



25-34 насны хүн амд дээд боловсрол эзэмшсэн хүмүүсийн эзлэх хувь



Эх сурвалж: “Монгол Улсын өрсөлдөх чадвар 2011” тайлангаас

ХӨГЖИЛ

БАГШ ТА...

Боловсролын “тархи” болсон багш нарын мэргэжлийн эзэд хэрхэн чанартай төгсөж байгааг эргээд нэг хараач...

Б.БАЯРТОГТОХ

Багшийн мэргэжил нийгэмд хамгийн нэр хүндтэй сайхан нь байсан. Багш хүний үнэлэмж, үнэ цэнэ, мэдлэг оюун өндөрт байсан учраас хүн бүр багшийн оюун бодол, эрдэм номд мөргөдөг байсан. Бүхнийг байсан гэж бичиж байгааг уучлаарай. Зах зээлд шилжсэнээс хойш багшийн нэр хүнд, үнэлэмж уруудсаар өнөөдөр хэн ч биш болж хувирав. Гэхдээ энд бүх багш нарыг хараар будаж буй юм биш. Шат шатны сургуульд оюуны өндөр мэдлэгтэй, өөрийгөө байнга хөгжүүлдэг, гадаад, дотоодод мэргэжил дээшлүүлсэн, хувь хүний үнэлэмж сайтай, бусдад үлгэр дууриал болж, хүндлэгдсэн багш нар бий. Гэхдээ боловсролын чанарын асуудлыг бичиж байгаа энэ үед бусдыг сурган хүмүүжүүлж, эрдэм оюуны хөтөч болсон багш нарын асуудлыг хөндөхгүй өнгөрч боломгүй. Багш нарын цалин хөлс, нийгмийн хангамж тааруу байна гэж сонин хэвлэлээр бичдэг. Багш нар ч өөрсдөө үе үе жагсаал цуглаан хийж энэ асуудлыг гаргаж тавьдаг. Тэглээ гээд тэдний хүсэл шаардлага биелэх биш, харин ч эсрэгээрээ нийгэмд байнга өндөрт байх ёстой нэр хүнд, үнэлэмж улам бүр буурсаар. “Багшийн эрдэм мэдлэг, заах арга, харилцаа, ёс зүй доройтжээ”, “Багш нь чадваргүй юм чинь сурагч нь чанаргүй байхаас ч яахав” гэх мэт үгсийг өнөөдөр хэн хүнгүй л хэлж байна. Боловсролын үнэлгээний газраас жил бүр ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдаас Стандартын түвшин тогтоох шалгалт авдаг. Өнгөрсөн онд 21 аймаг, нийслэлийн есөн дүүргийн 184 сургуулийн шигшмэл гэж болох 6000 гаруй сурагч тус шалгалтад хамрагдаж, хангалтгүй үнэлгээ авчээ. Шигшмэл гэсний учир нь сургуулиа төлөөлүүлж байгаа учир багш нар сайн гэсэн сурагчдаа түүж шалгалтад оруулсан байж таарна. Гэтэл тэдний 45 хувь нь шалгалтад арай чамай тэнцэж, үлдсэн нь “унасан” байдаг. Үүнд хэнийг буруутгах вэ. Багшийн заасан хичээлийг сайн сурч, давтаагүй сурагчдыг уу, сурагчдаа удирдан зохион байгуулж, анхаарлыг нь татаж, хичээлээ ойлгуулаагүй багшийг уу.

Урамшуулал чадварыг улам гялалзуулна

Багш нарт өрсөлдөөн алга. Сурагчдаа дэлхийн тавцанд өрсөлдүүлэх хүсэл алга. Хүсэл байлаа ч чадвар,



Фотог Б.Бямба-Очир

цаг зав алга. Цалингаас цалингийн хооронд, өрнөөс өрийн сүлжээнд баригдсан тэд заах арга, ур чадвараа сайжруулах, шавь нараа яавал сайн сургах вэ гэж бодох сөхөөгүй шар нар, бор хоногийг өнгөрөөж байна. Үүнийг өнгөрсөн жилийн багш нарын суулт, цалингаа нэмүүлэхийн төлөөх тэмцэл тод гэрчилнэ. Харин өндөр хөгжилтэй, гаднын оронд багш хамгийн өндөр цалинтай байдаг аж.

Багш бэлдэж байгаа багш нь цаг барьдаггүй, номноос хуулуулж, түүгээрээ шалгалт авдаг гээд алдаа дутагдлыг нь тоочоод байвал дуусахгүй. Харин түүнээс салах гарцыг хамтдаа хайя. ▶

► Дунд, их, дээд сургуулиудад цалингаа голж, цаг нөгцөөсөн багш цөөнгүй. Сургууль бүр 2008 оноос хойш багшийн үр дүнгийн цаг гэж улирал болгонд гаргах болсон. Тайлангаас нь үзвэл багш бүр 95-100 хувийн үр дүнтэй ажилласан байгаа. Гэвч бодит үр дүн болох төгсөгчдийн 65-70 хувь нь мэргэжлээрээ бус зөөгч, угаагч, худалдагч, түгээгч гэх мэтийн ажил хийж байна. Япон, БНСУ, Хонконг зэрэг орны сургалтын чанар сайн байдгийн гол шалтгаан нь багш ажлын цагтаа үр дүнтэй, сайн ажиллаж чаддаг тухай судалгаа үнэлгээ байдаг. Мөн тус улсуудад багш нарыг цалингаас гадна урамшууллаар тэтгэдэг байна. Ажлаа сайн хийсэн багш зөвхөн урамшууллынхаа мөнгөөр хангалуун амьдарч, үндсэн цалингаа хадгаламжиндаа хийдэг гэсэн. Илүү цаг болон сурагч, оюутнуудад заасан

хичээл нь үр дүнтэй байгаа болон хүүхдүүдэд зөв үнэлгээ өгч чадаж байгаа эсэхийг хөндлөнгөөс дүгнэж, урамшууллын хэмжээг тодорхойлдог байна. Харин улирал дараалан урамшуулал хүртээгүй багшийг идэвх зүтгэл муутай, үр чадварт дахин суралцах шаардлагатай хэмээн үзэж сургуулийн зүгээс дахин суралцуулах хүсэлт гаргадаг байна. Энэ систем нь багш нарыг давхар цалинжуулаад зогсохгүй хариуцлагатай, бүтээлч, сэтгэл хангалуун ажлаа хийдэг болгож буй явдал юм.

Монголын боловсролын салбарт ажиллаж буй 40 гаруй мянган багшийн 80 орчим хувь нь одоо авч байгаа цалиндаа сэтгэл дундуур байдаг тухай БШУЯ-ны Хяналт, шинжилгээ, үнэлгээний газраас хийсэн судалгаанд дурджээ. Иймээс дээрх аргыг үнэн зөв хяналтын дор нэвтрүүлбэл сайн

үр дүн гарна гэж тус салбарынхан ярьж буй. Зарим хувийн сургууль уг аргыг хэрэгжүүлж эхэлсэн нь багшийг хөгжүүлэх гол түлхүүр болж байгаа талаар “Олонлог” дунд сургуулийн захирал Д.Баяржаргал ярьж байсан.

Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Боловсрол, сэтгэл судлалын багш Б.Жавзан “Монголд чадвартай, дэлхийн хэмжээнд сэтгэдэг, олон сайн шавь төрүүлсэн мянга мянган багш бий. Мөн хөгшин, залуу гэлтгүй чадваргүй, мэдлэггүй, ёс зүйн доголдолтой хүмүүс ч байна. Сайн багшаас сайн шавь төрөх нь бодит үнэн зүйл. Тиймээс залуу багш нарыг гадаадын их, дээд сургуулиудад мэргэжил дээшлүүлэх нь юу юунаас чухал. Мөн багш нарын дунд шавь сургалтыг сэргээх хэрэгтэй. Багш нь багшдаа арга зүй, мэдлэг туршлагаа зааж, хамтдаа хөгжих нь үр дүнд ►►

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН

БОЛОВСРОЛ (шог өгүүллэг)



Шог зураач, зохиолч

Готов баян нийтийн жишгийг дагаж ганц хүүгээрээ малаа харуулж, охидоо боловсролтой болгоход мөнгө хайрлаагүй хүн. Баян аарагтаа бүү хэл сум аймагт цуутай баяны царай муутай шар охид эрдэм өвөртөлж ирэхээр хойно хойноосоо цувран одоо арав гаруй жилийн нүүр үзэв. Эцгийн зорьсон хэрэг бүтэж, таван охин бүгд дээд боловсролтой хуульч болжээ.

Гэвч энэ намар охид нь гэнэт

дэрхийтэл гэртээ ирцгээв. Том охин Цэцэгийнх нь ажиллаж байсан дэлгүүр мэргэжлийн худалдагчтай болж халсан гэнэ. Харин энэ хавар төгссөн отгон охин Навчаа нь зуны гурван сар хайгаад тохирох ажил олоогүй юм байх. Эмэг эхийнхээ балгаар эрхийн балай болчихсон, дунд охин Зулаа хэл амаа хазалж, таль түл дуугаран,

-Аав гэж нэг эрваа юм, морь унуулсаарбайгаадмайгаболгочихсон. Загвар өмсөгчид тэнцсэнгүй гэж хошуугаа цорвойлгон байн байн гунганахад эмэг эх нь аргадан авч гарна. Готовын уур дүрэлзэж,

-Загвардахад бараагүй юм бол заавардахад нь үзээд алдаг. Эцгийн буян байхад гэж дотроо үглэсээр, сумын төв рүү давхилаа. Үд өнгөрсөн тул дарга албан дээрээ байсангүй, сумын төвийг гурав тойрон сураглалаа. Улаан хүрэн үйтэн хуар дээлтэйгээ адил өнгийн хөнгөн тэрэг

хослуулан гангарсан Готов баянаар хорооны авгайчууд нүдээ хужирлана. Балбарын хуульч болоод ирсэн хүүгийн улаан хавтасны найрнаас Засаг даргыг сэм дуудаж гаргасан Готов олны нүднээс зайдуу Хийморь толгойн ард очиж тэргээ унтраагаад, хар “Чингис”-ийн бөглөө мулталлаа. Даргадаа хундага барих зуураа,

-Зулаа маань хуульчийн үнэмлэхтэй, гүйлгүүр ухаантай. Удирдах ажилд яг тэнцэнэ хэмээн эрхийн балай охиноо худлаа магтлаа. Найрын идээнд зориг зэгсэн чангарсан дарга:

-Готов ах нохойтохгүй шүү гэсэнэ хяхтнуулан хөхрөөд,

-Цэцэг чинь л сурлагатай, даргад тохирох хүн. Гэхдээ үнэнийг хэлэхэд манай сум долоон мянган үхэртэй, долоон мянга долоон хуульчтай болчихоод байгаа. Худлаа гэвэл тайлан мэдээ үз гэж байна. Дүгэрийн охин улаан хавтастай хуульч сургуулийн гал тогоонд сав угааж, түшмэл Нямын хүү хуульч зүйн зэрэг хамгаалсан Болдоо сумын уурын зууханд галчаар орж байгааг дарга Готовт учирлалаа. Тэгээд,

-Дүү нь хоншоортой шүү, Готов ах минь. Хоёр жил өвлийн идшээр харж үзсэн ачийг тань хариулалгүй яахав. ►►

► хүрэх болов уу гэж боддог” хэмээн ярьж байсан. Боловсролын салбарт гадаадын их, дээд сургуулийн туршлагаас цус сэлбэлт дутагдаж буйг хүн бүр хэлж байна. Соц нийгмийн сэтгэлгээ, программаар хичээлээ заадаг, шалгалтаа авдаг энэ байдал үеэ элээснийг гадна, дотнын сургуульд цол хэргэм хамгаалсан багш нар ярьдаг. Гэвч энэ байдал үргэлжилсэн хэвээрээ.

Хувийн их, дээд сургууль нэртэй хичээл заах үндсэн багш ч үгүй, байгаа хэд нь оюутны ширээнээс дөнгөж салсан “ногоон”-оороо хүмүүс боловсролын салбарыг улам бүр доройтуулж байна гэх атлаа нэгийг нь ч татанбуулгаж чадахгүйл байна. Гаднын орнуудын боловсролын хөгжлийн нэг онцлог нь бусад улсын чанартай, сайн сургуулиудын салбарыг сургалтын

бааз, багшлах боловсон хүчинтэй нь өөрийн улсдаа байгуулдагт байдаг аж. Гэтэл манайд дэлхийд нэртэй аль нэг сургуулийн салбар байна уу. Америк, Хятад сургалттай сургуулиуд байгаа ч сургалтын бааз, багш, арга зүй нь монголоороо л байна.

Багшийн илүүдэл үүсчээ

Монгол Улсын хэмжээнд жилд 35-38 мянган боловсон хүчин төгсөн гарч байгаагаас 6000 орчим нь багшийн мэргэжилтэй. Тэдний 2000 хүрэхгүй нь тухайн жилдээ ажилд ордог тухай Үндэсний статистикийн хорооны тайланд бий. Түүнчлэн Дорнод, Архангай, Ховд аймагт багш бэлтгэх сургуулиуд байдаг. Тус аймгуудын ойролцоох хөрш зэргэлдээ аймгуудад нийтдээ 500-600 багш идэвхтэй ажил

хайж байна гэсэн статистик судалгаа гарчээ. Тухайлбал, Хөвсгөл аймагт л гэхэд Монгол хэл, Уран зохиолын багшийн ганцхан орон тооны төлөө 25 багш өрсөлдсөн байх жишээтэй. Товчхондоо манайх багшийн илүүдэлтэй яваа гэсэн үг. Багшийн мэргэжлийн нэр хүнд уруудсан нь бараг л тааруу сурлагатай бол багш болдог гэсэн ойлголтыг сүүлийн жилүүдэд нийгэмд түгэн дэлгэрэхэд хүргэв. Түүнтэй зэрэгцээд мянга мянган багшийг их, дээд сургууль “үйлдвэрлэлээ”. Боловсролын “тархи” болсон багш нарын мэргэжлийн эзэд хэрхэн чанартай төгсөж байгааг эргээд нэг хараач. Мөн багш, сурган хүмүүжүүлэгчдийн зөвхөн мөнгө бодож суудаг сэтгэлгээг халж, гадаад, дотоодын сургалтад хамрагдаж, өөрийгөө хөгжүүлэхэд цаг зарцуулахыг нь дэмжээсэй. ■



► Танай Цэцэгийг шинэ оноос Тамгын газрын үйлчлэгчээр авъя. Яваандаа дарга болно биз гэлээ.

Үдийн саамны өмнө Готов гэрийн гадаа хөмөрсөн цагаан тогоог шамшиятал дайран, тэргээ чихруулан зогсоолоо. Гэрээрээ дүүрэн, ажилгүй шаагилдах хуульчид руугаа агсарч,

-Зулаа, Навчаа хоёр гүү саа, Цэцэг чи хувин ав, усанд яв. Чимгээ, Урнаа хоёр араг үүрээд аргал түү!.. Түргэлээч, муусайн үнээнүүд! Хуульчид та нар сумын үнээнээс ч

олуулаа гэл үү... хэмээн чарлалаа. Зулаа:

-Яг ш дээ, гүү сааж харагдаач гэж хэлээд тэрий хадталаа алгадуулан, ээрч муурлаа.

Маргааш өглөө нь Готовын толгой ангалзтал өвдөж, хажуугаар нь ээж, эхнэр хоёрын эрүүний шөл огиудас хүргэнэ. Хар бор ажил хийвэл охидын хуруу мойногших юм байх. Ийн сууж байтал гадаа хөнгөн тэрэг өчигдрийнхөөс ч чанга чихарлаа. Хуульч охид нь эцэгтэйгээ хуулиар үзэлцэхээр аймгаас хүчирхийллийн

эсрэг төвийнхнийг дуудуулсан нь энэ аж. Готов аймаг орж, сэнхэртлээ ном сонсоод, эмэгтэйчүүдийн эрхийг хүндэтгэж, цайгаа хүртэл өөрөө аягалж уудаг боллоо.

Готовын царай муутай шар охид хотод очоод төрөл арилжаад, сум бүү хэл аймагт байхгүй ганган дэгжин болоод ирсэн тухай амтай бүхэн ярьж байлаа. Тэднийхээр нутаг усандаа сурагтай, гайгүй сайн залуус бууж мордох боловч боловсролтой охидынх нь санаанд хэрийн хүн таарахгүй. “Энэ хэдийн царай ч дээ, гэртээ л өтлөх вий дээ” хэмээн Готов дотроо үглэх боловч, гадагш үл гаргана. Эхнэр, ээж хоёр нь гэр дүүрэн хуульчдын хоол ундыг санаанд нь тохиртол бэлдэх гэж зүдэрч байлаа.

Готов баяны нанчид хүртэх нь мэдэгдэм нэмэгдэж, ийм үедээ хуульчдаасаа жийрхээд холгүй нутаглах хүүгийн дээ очиж хононо. Тэрээр хүүтэй болно гэж зүтгэсээр дөрөв дэх царай муутай шар охиноо төрүүлээд байгаа хүү, бэр хоёртоо:

-Ээ дээ, хүүхдүүд минь. Наад хэдийгээ л хуульч болгочихвуузай хэмээн захиж, ганц лонх халаасан нэрмэл балгаад, суугаа чигтээ хурхирдаг болов. ■

2012-2013 оны хичээлийн жилийн “ИРЭЭДҮЙН МАНЛАЙЛАГЧ” тэтгэлэгт хөтөлбөрт урьж байна. Эх орныхоо ирээдүйг бүтээх чин хүсэл эрмэлзлэлтэй, амжилттай суралцаж буй оюутан залууст зориулсан Ирээдүйн манлайлагч сургалтын тэтгэлэгт хөтөлбөрийг зургаа дахь жилдээ зарлалаа.

Тавигдах шаардлага: Монгол Улсын магадлан итгэмжлэгдсэн их, дээд сургуулийн бакалаврын зэргийн өдрийн ангийн оюутан, голч дүн 3,5-аас дээш, оюутны эрдэм шинжилгээний ажилд амжилттай оролцож байсан, англи хэлийг дундаас дээш түвшинд эзэмшсэн байх

Сонгон шалгаруулалт: 2012 оны наймдугаар сарын 17-ноос есдүгээр сарын 25-ныг дуустал үндсэн гурван үе шаттай явагдана.

Боломж: Оюутны нэг жилийн сургалтын төлбөр, 1-2 жилийн хугацаанд сургалтын дүнг харгалзан амжилттай суралцсан оюутнуудад үргэлжлүүлэн тэтгэлэг олгох, тус группын аль нэг охин компанид үйлдвэрлэлийн болон дипломын дадлага хийх, улмаар тус компанид ажиллах урилга авах.

УТАС: 318283

E-mail: hr@monnis.com, www.monnis.com



ОЛОН УЛСЫН МВА-ИЙН СУРГАЛТАНД УРЬЖ БАЙНА



Хүнлэг нийгэм, оюунлаг ирээдүйн төлөө

Европын холбоо, АНУ, ОХУ болон зүүн Европын 20 гаруй их сургуулиудад хэрэгжиж байгаа олон улсын бизнесийн удирдлагын магистрийн “АГРИМБА” хөтөлбөрт 2011 онд Ази тивээс анх удаа элсэн орсон Монгол Улсын ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургууль нь хоёр дахь удаагийн элсэлтээ авч эхэллээ.

“АГРИМБА” хөтөлбөрийн бүртгэл 2012 оны аравдугаар сарын 15 хүртэл ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн 301 тоот өрөөнд явагдана.



WAGENINGEN UR
For quality of life

SGGW



Харилцах утас: 342218, 341777

И-мэйл: Graduate@seb.edu.mn



БАКАЛАВРЫН ДАРААХ ДИПЛОМЫН ХӨТӨЛБӨР



(Postgraduate Diploma in Business Management)

Хэрвээ та бизнесийн удирдлагаар ямар нэг зэрэгтэй бөгөөд Бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрт суралцах, эсвэл удирдлагын илүү өндөр албан тушаалд ажиллахыг хүсч байгаа бол энэ хөтөлбөрт хамрагдана уу. Энэхүү хөтөлбөр нь бизнесийн олон талбарын талаарх өргөн мэдлэгтэй болж, аль нэг чиглэлээр судалгаа хийж, суралцах боломж хайж буй хүмүүст зориулагдсан.

Суралцах хугацаа: 1 жил, 2 семестр оройн цагаар хичээллэнэ. Долоодугаар түвшний бизнесийн дипломын хөтөлбөрт бүх хичээл англи хэлээр явагдана.

Боломж: Энэхүү хөтөлбөрийг төгсөгч нь Их Британийн дараах сургуулиудад шилжин магистрын хөтөлбөрт суралцах, зэрэг хүртэхээс гадна Стратегийн түвшний үйл ажиллагааны менежмент, маркетинг, хүний нөөцийн менежмент зэрэг талбарт дээд түвшний ажил алба эрхлэх боломжтой болдог.

[University of Gloucestershire](#)
[University of Huddersfield](#)
[University of Worcester](#)

Сургалтын төлбөр: 1 жил – 7000 ам.доллар

Элсэхэд тавигдах шаардлагууд:

- Их Британийн болон бусад орны их, дээд сургуулийн бакалаврын зэрэгтэй байх эсвэл
- Удирдлагын түвшинд тодорхой нөөц сурвалж захиран зарцуулах эрх мэдэлтэй ажил алба гурваас доошгүй жил эрхэлсэн байх. Суралахыг хүсэгч нь бие даан шийдвэр гаргаж, нөөц удирдаж ажиллаж байснаа нотлох чадвартай байна. Суралцуулах шийдвэрийг Эн Си Си Боловсрол байгууллага гаргана.
- Өргөдөл гаргагчийн төрөлх хэл нь англи хэл биш бол IELTS-ын 6.5-аас доошгүй оноотой байх, эсвэл Эн Си Си Боловсрол байгууллагын бакалаврын дараах дипломын сургалтад шаардагдах англи хэлний шаардлагыг хангасан бичиг баримттай байх ёстой.

Бидэнтэй холбоо барих:

Хаяг: МУИС-ийн Эдийн Засгийн Сургууль, 216 тоот,
Менежментийн тэнхим
Утас/Факс: 77307730-4120, 351940
Цахим хаяг: www.ncc.ses.edu.mn

Цахим шуудан: NCCatSES@gmail.com
Facebook: www.facebook.com/NCCatSES
Twitter: [@NCCatSES](https://twitter.com/NCCatSES)
Youtube: [NCCatSES](https://www.youtube.com/NCCatSES)
Flickr: [NCCatSES](https://www.flickr.com/photos/NCCatSES/)

ОХУ-ЫН “Г.В.ПЛЕХАНОВЫН НЭРЭМЖИТ ЭДИЙН ЗАСГИЙН ИХ СУРГУУЛЬ

ОХУ-ын “Г.В.Плехановын нэрэмжит Эдийн засгийн их сургууль”-ийн Улаанбаатар хотын салбар сургууль нь 2012-2013 оны хичээлийн жилд Эдийн засгийн бакалавр, Олон улсын бизнес, эдийн засгийн магистрийн сургалт, орос хэлний бэлтгэл факультет болон ЕБС-ийн 1-11 дүгээр ангиуддаа элсэлт авч байна.

Утас: 450679, 460073

ТҮВШИН ТОГООЛТ

МЭДЛЭГИЙН ЭРИН ҮЕИЙН СУРГАЛТ

Хөгжилтэй, хөгжиж буй, буурай гээд бүх л улс орон өөрийн боловсролын тогтолцоо, шинэчлэлд анхаарал хандуулдаг. Дэлхийд аль улс сурлагын түвшингээр тэргүүлдэг бол? Тэгвэл дэлхий дахинаа энэхүү үзүүлэлтийг хэмжиж, орнуудыг сурлагаар нь жагсаадаг хөтөлбөр байдаг байна.

Х.ХУЛАН

Даяаршиж буй дэлхий дээр мэдлэг, мэдээлэл нь эдийн засгийн хөгжил цэцэглэлтийн гол түлхүүр болжээ. Бид мэдлэгийн эрин нэртэй XXI зуунд амьдарч байна. Ийм ч учраас боловсролын асуудлыг олон улсын тавцанд хурцаар дэвшүүлэх боллоо. Хөгжилтэй, хөгжиж буй, буурай гээд бүх л улс орон өөрийн боловсролын тогтолцоо, шинэчлэлд анхаарал хандуулдаг. Дэлхийд аль улс сурлагын түвшингээр тэргүүлдэг бол? Тэгвэл дэлхий дахинаа энэхүү үзүүлэлтийг хэмжиж, орнуудыг сурлагаар нь жагсаадаг хөтөлбөр байдаг байна.

PISA

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) оюуны бүтээл болох Пи Ай Эс Эй (PISA, Programme for International School Assessment) нь олон улсын сурагчдын үнэлгээний хөтөлбөр юм. ЭЗХАХБ нь 34 гишүүн оронтой. 1990-ээд оны сүүлчээр тус байгууллагын гишүүн орнууд дэлхийн 15 настай сурагчдыг нийгэмд хэрхэн бэлтгэгдэж буйг тестээр хэмжих санаачилга гаргажээ. Чухам яагаад 15 настай сурагчдыг сонгосон бэ гэвэл ихэнх орны 15 настнууд энэ үед зайлшгүй үзэх боловсролоо дүүргэсэн байдаг аж. Гурван жил тутамд нэг удаа явуулдаг энэхүү тест нь оролцогч сурагчдын математик, уншиж ойлгох, шинжлэх ухааны мэдлэгийн хүрээг

шалгадаг байна.

Хоёр цаг үргэлжилдэг тус шалгалтын гол зорилго нь сурагчид сургууль дээр үзсэн мэдлэгээ бодит амьдралд хэрхэн оновчтой ашиглах чадвартайг тодорхойлоход оршино. Шалгалтын үнэлгээнээс тухайн улсын боловсролын тогтолцооны дүр зураг олон улсын хэмжээнд ямар байгаа нь харагддаг ажээ. Өөрөөр хэлбэл, Пи Ай Эс Эй нь оролцогч улс орны түвшинг бусад улстай харьцуулсан дүн ямар байгаа, мөн сурагчдаа хэр үр дүнтэй сургаж чадаж байгааг харуулдаг. Шалгалтын үр дүнд дэлхийн боловсролын системийн ижил ба ялгаатай тал тодордог байна. Ингэснээрээ төр, засаг боловсролын салбарын бодлоготоо үнэлэлт, дүгнэлт хийж, сурагчдын сурлагыг хэрхэн сайжруулах тал дээр шинэ бодлого боловсруулахад дөхөм болдог ажээ. ЭЗХАХБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга Анжел Гуррия “Сургалтын амжилт нь ирээдүйн эдийн засгийн өсөлтийн чухал хэмжүүр” гэж тэмдэглэж байна.

Ямар улс онц сурдаг вэ?

Анх 2000 онд нийт 32 орон Пи Ай Эс Эйд оролцож байсан бол 2009 онд энэ тоо 67-д хүрчээ. Энэ онд харин 68 улс оролцож байгаа нь тус шалгалтын нэр хүнд хэрхэн өсөж байгааг тодотгоно. Финландын 15 настнууд 2000, 2003, 2006 онд гурван удаа нэгдүгээр байр

эзэлж, сурлагаараа шилдэг болохоо харуулсан билээ. Гурвын гурван удаа Пи Ай Эс Эй-ийн ялагчаар тодорсон Финландын сурлагын амжилтын нууцыг олон хүн мэдэхийг хүссэн. Иймд дэлхийн өнцөг бүрээс судлаач, сурган хүмүүжүүлэгч нар 5.4 сая хүн амтай тус орныг зорих болсон.

2009 оны Пи Ай Эс Эй-н эхний арван байрт шалгарсан орнуудад Хятад, БНСУ, Финланд, Хонконг, Сингапур, Канад, Шинэ Зеланд, Япон, Австрали, Голланд оржээ. Энэ нь Азийн тэргүүлэх хөгжилтэй “бар” орнууд, Европын их гүрнүүдтэй сурлагаар тэнцүүхэн тоон харьцаатай болсныг илтгэж байна.

Финландын сургалтын нууцаас

Японы Боловсрол, технологийн яамны ажилтан Финландын нийслэл Хельсинкид туршлага судлахаар иржээ. Тэрбээр “Финланд багш, сурагчдын хоорондын харьцаа сайн, дотно талдаа байна. Японд багш, сурган хүмүүжүүлэгчид маш хатуу” гэсэн дүгнэлт хийв. Дэлхий даяар тус орны сурган хүмүүжүүлэх арга ухааныг бишрэн шүтэж байхад финландчууд харин сургалтдаа шүүмжлэлттэй хандаж байх жишээтэй. Тэд “Бид нар залхуу”, тэр ч байтугай “Ихэнх багш хичээлээ чөлөөтэй бус хэтэрхий номын дагуу заадаг” гэсэн байдаг.

Гэсэн ч тааруу сурлагатай сурагчтай ажиллах бодлого, арга ▶



► барилаараа финляндчууд сайн гэдэгтэй тэд санал нэгтэй байна. “Чухам энэ л бидний Пи Ай Эс Эй-д гаргадаг амжилтын шалтгаан болов уу гэж” давтлага зохион байгуулагч Пирйо Коивула хэлэв. Тааруу сурлагатай сурагчдад улсаас гурван үе шаттай давтлага санал болгодог байна. Энэхүү давтлагын эхний төрөлд ангийн багш сурлагаар хоцорч буй сурагчидтай тулж ажилладаг. Дараагийн үе шатныханд “Тусгай сургалт” шаардлагатай сурагчдыг хамруулдаг байна. Үүнийг хичээлийн цагаас гадуур сурагчдад ганцаарчилсан юм уу, бүлгээр хичээл заадаг аж. Бага ангийн сурагчдын тавны нэг нь энэхүү дэмжлэгийг авдаг байна. Давтан сургалтын гурав дахь төрлийг “онцгой” тохиолдолд хэрэгжүүлдэг. Тухайн сурагчийн үзэх хичээлийг багш, сэтгэл зүйч хоёр хамтран бэлддэг байна. Тэд ангидаа үлдэж, хичээлээ тусгайлан бэлтгэгдсэн багшаар заалгадаг байна. Давтлага авдаг сурагчдын эцэг эхтэй нягт хамтарч ажиллахыг багш нар мэрийдэг. Ар гэрээс нь үл тоомсорлож, хүүхдийнхээ

сурлагад анхаарахгүй тохиолдолд ч сургууль тусалдаг. Учир нь багш, сурган хүмүүжүүлэгчид тааруу сурлагатай хүүхдийг буруушаахгүй, харин ч хүүхэд бүр тэгш эрхтэйгээр суралцахыг тунхагладаг. “Хэнийг ч хоцроохгүй” гэсэн нийгмийн уриатай ажээ. Тиймээс хөгжлийн бэрхшээлтэй, ямар нэгэн өвчин эмгэгтэй хүүхдийг жирийн сургуульд сургадаг. Эдгээр хүүхдэд тусгай сурган хүмүүжүүлэгч багш хичээл ордог. Жишээ нь, Тампере хотын сурагч найман настай Миа анх ангидаа ирэхдээ нэрээ ч зөв дуудаж чаддаггүй байсан бол өнөөдөр багш нарын хөдөлмөрийн ачаар баг болж ажиллах чадвартай болсон аж. Эдгээр дурдсан жишээнүүд бол Финляндын боловсролын тогтолцооны нэгээхэн хэсэг юм. Бүх сурагч суруулийнхаа цайны газарт цайнд орох үүрэгтэй. Түүнчлэн ангийн багшаас гадна сургууль бүр туслах, сэтгэл зүйч, тусгай мэргэжлийн багштай байгаа нь сурагчдын сурлага болоод бусад амжилтад нөлөөлдөг аж.

PISA юуг өгүүлнэ вэ?

Пи Ай Эс Эй шалгалтад олон улсын 15 настнууд өндөр оноо авахдаа бус, харин нийгмийн бүх давхаргынхан сорилоо хийж чадаж байна уу гэдэгт анхаардаг. Жишээ нь: Хонконг, Шанхай, БНСУ, Финляндын эмзэг бүлгийн харьцангуй олон сурагч хамгийн өндөр оноог авсан байна. Шинжээчид шалгалтын дүнтэй танилцаж, сайн боловсролын тогтолцооны гол шинж чанарыг тогтоодог.

Мөн Пи Ай Эс Эй унших чадварын шалгалтыг охидууд хөвгүүдээс илүү сайн хийдгийг тогтоосон. Хөвгүүд харин математикийн сорил дээр охидоос өндөр оноо авдаг байна. Сонирхолтой нь, эмзэг бүлгийн сурагч олонтой сургуулийн сурагчдын сурлага дорддог гэнэ. Эдгээр сургуулийн багш нарын тоог судлахад бусад сургуулиудтай ижил байсан байна. Тэгвэл юу нөлөөлсөн байх уу? Заах аргаар чадварлаг багш нар ихэнх тохиолдолд сурлагаараа тэргүүлдэг сургуулиудад ажилладаг нь тогтоогджээ. ■

2009 онд Пи Ай Эс Эйд оролцсон орнуудыг оноогоор жагсаасан нь

	Нийт унших шалгалтын оноо	Бүтээлчээр унших дээд оноо				Тооны ухааны шалгалтын оноо	ШУ-ны шалгалтын оноо
		Текст ойлгох чадвар	Текстэд дүгнэлт хийх	Үргэлжилсэн текст	Үргэлжилсэн бус текст		
OECD-гийн дундаж	493	493	494	494	493	496	501
Шанхай	556	549	558	557	564	539	600
БНСУ	539	541	542	538	542	546	538
Финлянд	536	538	536	535	535	541	554
Хонгконг	533	530	540	538	522	555	549
Сингапуре	526	525	529	522	539	562	542
Канад	524	522	535	524	527	527	529
Шинэ Зеланд	521	517	531	518	532	519	532
Япон	520	520	521	520	518	529	539
Австрали	515	513	523	513	524	514	527
Нидерланд	508	504	510	506	514	526	522
Бельги	506	504	505	504	511	515	507
Норвеги	503	502	505	505	498	498	500
Эстони	501	500	503	497	512	512	528
Швейцарь	501	502	497	498	505	534	517
Польш	500	503	498	502	496	495	508
Исланд	500	503	496	501	499	507	496
АНУ	500	495	512	500	503	487	502
Лихтенштейн	499	498	498	495	506	536	520
Швед	497	494	502	499	498	494	494
Герман	497	501	491	496	497	513	520
Ирланд	496	494	502	497	496	487	508
Франц	496	497	495	492	498	497	498
Тайпэй	495	499	493	496	500	543	520
Дани	495	492	493	496	493	503	499
Англи	494	491	503	492	506	492	514
Унгар	494	496	489	497	487	490	503
Португаль	489	487	496	492	488	487	493
Макао	487	488	481	488	481	525	511
Итали	486	490	482	489	476	483	489
Латви	484	484	492	484	487	482	494
Словени	483	489	470	484	476	501	512
Грек	483	484	489	487	472	466	470
Испани	481	481	483	484	473	483	488
Чех	478	488	462	479	474	493	500
Словак	477	481	466	479	471	497	490
Хорват улс	476	472	471	478	472	460	486
Израиль	474	473	483	477	467	447	455
Люксембург	472	475	471	471	472	489	484
Австри	470	471	463	470	472	496	494
Литва	468	469	463	470	462	477	491
Турк	464	459	473	466	461	445	454
Дубай	459	457	466	461	460	453	466
ОХУ	459	467	441	461	452	468	478
Чили	449	452	452	453	444	421	447
Серби	442	445	430	444	438	442	443
Болгар	429	436	417	433	421	428	439
Уругвай	426	423	436	429	421	427	427
Мексик	425	418	432	426	424	419	416
Румын	424	425	426	423	424	427	428
Тайланд	421	416	420	423	423	419	425
Тринидад, Тобаго	416	419	413	418	417	414	410
Колумб	413	411	422	415	409	381	402
Бразиль	412	406	424	414	408	386	405
Монтенегро	408	420	383	411	398	403	401
Йордан	405	410	407	417	387	387	415
Тунези	404	393	427	408	393	371	401
Индонез	402	397	409	405	399	371	383
Аргентин	398	398	402	400	391	388	401
Казахстан	390	397	373	399	371	405	400
Албани	385	393	376	392	366	377	391
Катар	372	379	376	375	361	368	379
Панам	371	372	377	373	359	360	376
Перу	370	371	368	374	356	365	369
Азербайджан	362	373	335	362	351	431	373
Киргистан	314	327	300	319	293	331	330

Эх сурвалж: OECD, PISA

ҮЗЭЛ БОДОЛ

ФИНЛЯНДЫН БОЛОВСРОЛЫН ШИНЭЧЛЭЛЭЭС СУРАХ ЮМ ИХ БАЙНА

Б. ОТГОНТӨГС

/МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн профессор,
дэд захирал Боловсролын эдийн засгийн ухааны доктор/.

1992 онд ОХУ-ын М. В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургуулийг эдийн засгийн онолоор бакалавр зэрэгтэй, 1998 онд Их Британийн Манчестрийн их сургуульд магистр, 2010 онд АНУ-ын Колумбийн их сургуульд боловсролын эдийн засгийн онолоор докторын (PhD) зэрэг тус тус хамгаалжээ.



Монгол Улсын хувьд сургуулийн өмнөх, бага, дунд болон дээд боловсролын хүртээмж сайжирч байгаа боловч тэгш байдал, чанарын асуудал тун чухал хэвээр байна. Бид боловсролын системээ анх бий болгохдоо, шинэчлэн өөрчлөх явцдаа бусад орны туршлагад үргэлж тулгуурлаж ирсэн. Шинэчлэл, өөрчлөлт үргэлжилсээр байна.

1970 онд дэлхийд боловсролын системийн хөгжлөөрөө АНУ, Их Британи, ОХУ тэргүүлж байсан бол тухайн үед 4.5 сая хүн амтай байсан Финлянд улс нэлээд доогуур жагсаж байв. Гэтэл Финлянд боловсролын системдээ АНУ-ын эсвэл Их Британийн системийг хуулбарлахгүйгээр маш өвөрмөц шинэчлэл хийж чадсанаар 20-30 жилийн дараа бага, дунд боловсролын чанараараа дэлхийд эхний нэгд орж байна. Өндөр хөгжилтэй 34 орныг эгнээндээ багтаасан Эдийн Засгийн Хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллагын (OECD) орнуудын дотор сүүлийн жилүүдэд Финляндын сурагчид PISA (Program for International Student Assessment) шалгалтын дүнгээр хэл, математик, байгалийн шинжлэх ухааны суурь мэдлэгээр эхний нэг, хоёрдугаар байрт орж байна. Финляндын сурагчдын авсан оноо бусад орны сурагчдынхаас өндөр байгаад зогсохгүй сургуулиудынх нь дундаж онооны хэлбэлзэл нь таван хувь бол бусад өндөр хөгжилтэй орнуудын хувьд энэ хэлбэлзэл 33

хувьтай байна. Өөрөөр хэлбэл, Финляндын сургуулиудын хооронд нэг их ялгаа байхгүй байна гэсэн үг. Хот, нийслэл, төвийн сургуулиудын сурагчдын оноо өндөр харин хөдөө, тосгоны сургуулиудад суралцагсдын оноо доогуур биш, ерөнхийдөө жигд өндөр оноог шалгалт бүрт авч чадаж байгаа нь энэ улсад боловсролын чанар өндөр бөгөөд хүртээмж нь тэгш байгааг харуулж байгаа юм. Судлаачдын хамгийн сонирхол татаж байгаа зүйл бол (I) Финляндад бүх сурагчдыг оноогоор үнэлдэг нэгдсэн тестийн систем байхгүй, сургуулиуд өөрсдөө сургалтын хөтөлбөрөө үнэлэхийн тулд зөвхөн хоёр ба есдүгээр анги төгссөн сурагчдаас түүвэр судалгаагаар зарим сурагчдыг сонгон авч шалгалт авдаг (II) Хятад, Тайвань, Япон, Өмнөд Солонгос зэрэг оронд ажиглагддаг шиг сурагчдад гэрийн даалгавар их өгдөггүй бөгөөд амралтын өдрүүд, улирлын, зуны амралтаар даалгавар огт өгдөггүй, (III) Финляндад зөвхөн нэг, хоёр үндэстэн ястан голлон амьдардаг бус сүүлийн жилүүдэд ихээр нэмэгдэж буй цагаачлал, тухайлбал, Афганистан, Иран, Ирак, Босниа, Серб, Энэтхэг, Турк, Тайланд, Вьетнам зэрэг орноос ихээр ирж байгаа хүмүүсийн хүүхдүүд, тус орны уугуул сурагчид ийм өндөр амжилтыг жил дараалан гаргаж байгаа явдал юм. Зөвхөн арван жилийн сургуулиуд нь амжилттай байгаад зогсохгүй, нийт хүн амынх нь боловсрол олж авах, түүнийгээ

хэрэглэх нь амжилттай байна. Тухайлбал, Финляндын нийт хүн амын гуравны нэг нь дээд боловсролтой бөгөөд их дээд сургууль төгсөгчдийн 30 хувь нь байгалийн шинжлэх ухааны чиглэлээр мэргэшиж, OECD орнуудын дунд нэг хүнд ногдох эрдэм шинжилгээний өгүүллээр, патентийн тоогоороо эхний тавд орж байна. Хүн амын тал хувь нь ямар нэгэн сургалтад хамрагдаж байна.

Боловсролын шинэчлэлийг нь судалбал, 1970-аад оны эхээр Финлянд боловсрол олгох боломжийг аль болох тэгш байлгахыг зорин Герман, Австри, Швейцарь зэрэг орнууд шиг сурагчдыг шалгалтын оноогоор нь өөр өөр түвшний сургалтын чиглэлээр (энгийн түвшний эсвэл шинжлэх ухааны чиглэлийн гэх мэт) салган, хувааж сургадаг байснаа зогсоосон байна. Ахлах сургууль төгстөлөө үздэг сургалтын киррикулум бүх сурагчдын хувьд ижил жигд болж ирсэн. Энэ нь сурагч бүрт цаашид их сургуулийн боловсрол олж авах боломжийг нээж өгсөн байна. 1970-аад оны эцсээр багш нарыг шинээр бэлдэх, дахин сургахад хөрөнгө оруулалт хийсэн. 1972-1982 оны хооронд сургуулиудын сургалтын хөтөлбөрийн болон багш нарын сургалт, заах арга болон үнэлгээний биеэ даасан байдлыг урамшуулах, сурагчдын хоол тэжээл, эрүүл мэнд, шүдний эмчилгээ, тээвэрлэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтыг өргөжүүлэх бодлогыг хэрэгжүүлсэн байна. 1990 ▶

▸ оны дунд үеэс боловсролын яамны тогтоодог, хянадаг, үнэлдэг нэгдсэн, нэг ижил сургалтын хөтөлбөрөөс татгалзаж, хот, тосгон, сургуулиуд хамтран өөрсдийн орон нутгийн онцлог, сурагчдын бүтэцдээ тохирсон сургалтын хөтөлбөр, үнэлгээний системийг боловсруулан, туршиж, дахин хянаж, боловсруулдаг болжээ. Харин 1990-ээд оны сүүлчээр сурагчдыг хэрхэн creative thinking буюу бүтээлчээр, шинээр, өөрөөр бодож, шийдэл олох ур чадвартай болгох вэ гэсэн зорилт тавин математик, байгалийн шинжлэх ухааны хичээлийн хөтөлбөрүүдийг шинэчлэн зааж эхэлсэн байна. Эхлээд багшийн их сургуулиуд дээр багш нарыг хэрхэн бага, дунд ангиудад математикийн хичээлийг хүүхдүүдийн сонирхлыг татахаар, энгийн, ойлгомжтой заах талаар тусгайлан бэлдэж эхэлсэн. Мөн багшийн их сургуулийн математикийн багш нар бага, дунд, ахлах сургуулиудад математик заадаг багш нарын хичээл дээр очиж, ажиглалт, туршилт хийн, зарим тохиолдолд хамтран зааж, заах аргуудыг дахин сайжруулж, боловсруулсан байна. Дараачийн шатанд бага, дунд, ахлах сургуулиудад математик заадаг багш нар өөрсдөө “Математикийн клуб” байгуулан, хамтран сургалтын хөтөлбөр зохиох, бодлого зохиох, олсон мэдлэгийг шалгах арга барилаа өөрчлөх, сайжруулах зэрэг


олон асуудлаар санал, бодлоо солилцдог болсон. Энэ явцыг улс төрчид, боловсролын бодлого боловсруулагчид, хэвлэл мэдээлийн хэрэгслүүд ихээхэн дэмжиж, нийтэд түгээж, сурталчилж байсан байна.

Финлянд хэрхэн богино хугацаанд боловсролын ийм өндөр амжилтад хүрч чадав гэсэн асуултад Финляндын бодлого судлаач Pasi Sahlberg хариулахдаа “Гол нь сүүлийн 20-30 жилийн туршид янз бүрийн түвшний сурах чадвартай бүх хүүхдийн ойлгож, сурч, мэдэх нөхцөлийг нь хангаж чадахуйц мэргэжлийн өндөр чадвартай багш нарыг бэлдэхэд улсаас ихээхэн хөрөнгө, хүч зарсан бөгөөд нэг төрлийн стандартыг, шалгалт, тестийн системийг гол болголгүй, өрсөлдөөнд түрүүлэхдээ биш, жигд, бүгдийг сургах гэсэн бодлого явуулсанаар ийм амжилтад хүрсэн” хэмээн тайлбарлаж байна. Бүх сурагч сургууль дээрээ өдрийн хоол үнэгүй идэхээс гадна, эрүүл мэндийн үзлэг, сурах бичиг, автобусаар үнэгүй үйлчлүүлдэг байна. Багш нар нь тэдэн ангид, тэдэн цагийн хичээл заасан, шалгалтын дундаж оноо тэд байна гэж тайлан гаргахаасаа илүү ямар бэрхшээл, ахиц дэвшил гарав, тухайн ангийн хүүхдүүд аль хэсэг, сэдэв дээр илүү цаг шаардав, цаашид яах ёстой байна, сургууль үүн дээр хэрхэн анхаарвал зохих зэрэг сургалтад, заах арга барилдаа, боловсролын менежментэд чиглэсэн

тайлан бичдэг, тайлангаа сургууль, хот, улсын хэмжээнд хамтран ярилцдаг, тараадаг байна.

Финляндын бодлого боловсруулагчид энэ амжилтыг багш нарын боловсролын чанарт ихээхэн хөрөнгө оруулалт хийснээр тайлбарлаж байна.

Станфордын их сургуулийн профессор L. Darling-Hammond тайлбарлахдаа, Финляндын сургуулийн болон ангийн хэмжээ бага, дунджаар 300 сурагчтай, нэг ангид дунджаар 20 орчим сурагч ногддог бөгөөд сургуулийн захирал нь аж ахуйн эсвэл багш нарын хурал зөвлөлгөөнд анхаарал хандуулахаасаа илүү сурагчдад, тэдний амжилт, хоцрогдол, эрүүл мэнд, сэтгэл санаа болон ар гэрийн байдалд нь анхаарал хандуулж, шаардлагатай тохиолдолд нэмэлт хичээлд суулгах, эсвэл дугуйлан, секцэд хамруулахыг зөвлөдөг байна. Профессор L. Darling-Hammond-ын ажигласнаар Финляндын жирийн аль ч ангид нэг багш 20-25 сурагчийн өмнө зогсоод, өөрөө 45 орчим минут яриад, бичээд байхгүйгээр аль болохоор хүүхдүүдийн асуулт асуухыг урамшуулдаг, арын ширээний орчмоос зөвлөгөө өгдөг, сурагчдын асуултад нь хариулдаг, тухайн сэдвийг яг тэр өдөр, тэр цагт төлөвлөгөөний дагуу зааж дуусгах ёстой гэдгээр биш хүүхдүүдийн өөрсдийн уншиж, бичиж, бодож, тооцоолж байгаа хурдад тохируулан хичээлээ заадаг байна. Түүний дүгнэж байгаагаар Финляндын сургалтын системийн амжилт нэгдүгээрт, багш болох гэж байгаа оюутнуудад олгож байгаа чанартай сургалт, хоёрдугаарт, багш болоод ажиллаж байгаа хүмүүст олгож байгаа сургалт, гуравдугаарт, багшийн ажлын нэр хүндийг нийгмийн бодлогоор тасралтгүй дэмжиж өгч байгаа явдал. Дөрөвдүгээрт, АНУ болон Их Британид хэрэгжүүлж байгаа бодлогоос тэс өөрөөр, тухайлбал боловсролын төв байгууллагаас, яамнаас өгсөн сургалтын нэгдсэн ижил хөтөлбөрт, үнэлгээний системд баригдахгүйгээр хүүхдүүдийг яавал сургалтын стандартад хүргэх вэ гэсэн өөрийн гэсэн сургалтын хөтөлбөр, программ, үнэлгээний болон дахин сургалтын систем, багш нар өөрийн



▶ гэсэн арга барилтай ажилладаг оршиж байна” гэж дүгнэсэн байна.

Финляндын Joensuu их сургуулийн профессор G.Малату энд дурьдсан бүх хүчин зүйлстэй санал нэгтэй байгаа бөгөөд түүний нэмж тайлбарласнаар, Финляндын сургуулиудын цомхон, багш сурагч болгон нэг нэгийгээ мэддэг, тохь тухтай, аюулгүй байдал, хэт их өрсөлдөөнийг дэмждэггүй бодлого, гол нь хүүхдийг ирээдүйн амьдралд нь бэлтгэхдээ биш одоо байгаа хүүхэд насны амьдралыг нь сайн сайхан, тэгш, бүтээмжтэй, сонирхолтой байлгахыг зорьдог учраас сурагчид нь сургуульдаа очих дуртай, өдрийн хоолон дээрээ ангийн найз нартай ярих, хөгжилдөх, тоглохоо эрхэм болгодог, шалгалт, хяналтын ажлаа хуулахгүй, стрессгүйгээр, сонирхож өгч сурсан байна.

Финлянд Монголын боловсролын системд ижил төстэй зүйл их бий. Тухайлбал, хоёулаа парламентийн засаглалтай, хүн ам цөөтэй, сийрэг суурьшсан (Монгол Улс 2.7 сая хүн амтай, Финлянд улс 5.4 сая хүнтэй), өвөл нь хүйтэн, удаан 4-5 сар үргэлжилдэг бол богинохон зунтай, орон нутгийн засаг захиргааны тоо хэмжээ нь ижил (Монгол Улс 340 сумтай, Финлянд улс 336 хот тосгонтой), үндсэн нэг хэлээр ярьдаг (Монгол, Казак хэлээр боловсрол олгодог бол Финлянд Финн хэлээр болон зарим мужид Швед хэлээр

боловсрол олгодог), боловсролын санхүүжилтийн 90 хувийг төрөөс санхүүжүүлдэг, дээд боловсролоос бусад түвшинд бол төрийн өмчийн сургуулиуд давамгайлдаг зэрэг ижил тал цөөнгүй бий. Бидэнд Финляндын гаргаж байгаа амжилтанд хүрэх боломж бий.

Бид сургалтын бүтэц, боловсролын стандарт, сургалтын агуулга хөтөлбөр, ном сурах бичгүүдээ шинэчлэхийн хажуугаар багш нарыг бэлтгэх сургалтад, багшаар ажиллаж байгаа сурган хүмүүжүүлэгч нарыг дахин сургахад илүү хөрөнгө оруулалт хийх хэрэгтэй байна. Сургуулиудын санхүүжилтийн төвлөрлийг сааруулах, биеэ даасан байдлыг илүү олгож, улам сайжруулах, багш нарын онолын мэдлэг, сургах, заах аргын биеэ даасан байдлыг урамшуулах, сурагчдын хоол тэжээл, эрүүл мэнд, шүдний эмчилгээ, тээвэрлэлт, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн сургалтыг өргөжүүлэх зэрэгт оруулах хөрөнгө оруулалтыг улам үр өгөөжтэй болгох хэрэгтэй байна. Дотоодын эдийн засгийн өсөлт хурдацтай байгаа өнөө цагт бид бусад орны туршлага, сургамжуудаас санаа авахдаа туйлшрахгүйгээр, дотоодын багш, судлаачдын хийсэн судалгаа, орон нутаг дахь туршилт, хэлэлцүүлэгт үндэслэсэн, олон талын оролцогчийн санаа оноонд суурилсан бодлого хэрэгжүүлэх хэрэгтэй байна. ■

ГАДНЫ ХҮНИЙ НҮДЭЭР

“ЭЛИТ СУРАГЧДАД” ЭЛИТ БОЛОХ БОЛОМЖИЙГ НЭЭХ ХААЛГА

Жил ирэх тусам сургуулиудын төлбөр өсөж байгаа ч сургуулиуд төгсөгчдөө ажлын талбарт хэрхэн үдэж байна вэ?

ТЕРЭНС ЭДВАРДС

“Mongolian economy” сэтгүүлийн англи хэлний редактор

Хичээлийн шинэ жил айсуй. Сурагчийн Хширээгээ сэлгэн оюутан насаа угтахаар зэхэж буй нь олон. Харин амьдралын өөр нэг хаалгыг татаж байгаа залуус мөнгөн хонхны баяраа хэдхэн сарын өмнө тэмдэглэсэн билээ. Улсынхаа хөгжилд хувь нэмрээ оруулах залуусын ихэнх нь ажилчин ангийн эгнээнд элсэх ээлжээ хүлээсээр байна. Тэдний зарим нь хангалтгүй гэх шалтгаанаар хүссэн ажилдаа орж чадахгүй байгаа нь нууц биш. Тэгвэл Монголын ирээдүй болсон залуус чадварлаг ажиллах хүчин болж авлигагүй нийгэм, эрүүл эдийн засагт шилжихэд бэлэн үү?

Ард түмний хүсэл, зорилго тэнгэр өөд

тэмүүлж байгаа ч чадвар, зүтгэл үгүй бол улсынхаа хөгжлийг хөлдөө чирч, дэлхийн хөгжлийн “баян ходоод” болох аж. Их сургуулиа төгсөх нь амжилтын анхны алхам байдаг. Гэвч амжилт дуудах анхны тэр алхам насан туршийн азгүйтлийг ч дагуулах нь бий.

Асуудлын үндэс

Жил ирэх тусам сургалтын төлбөр өсөж байгаа ч сургалтын чанар ахихгүй байгаа нь харамсалтай. Ирэх хичээлийн жилийн сургалтын төлбөр 25-50 хувиар өснө гэх мэдээлэл байна. Харин өндөр төлбөрийг ▶

▶ дагаад сургалтын систем чанаржсан гэвэл үнэнд нийцэхгүй болов уу. “Үндэсний шуудан” сонины дөрөвдүгээр сарын нэгэн дугаарт 2011 онд төгссөн нийт 40 мянган оюутны 3/1 нь л ажлын байртай байгаа тухай нийтэлсэн байна. Сүүлийн жилүүдэд их, дээд сургуулиудын сургалтын хөтөлбөрт цөөнгүй өөрчлөлт оруулсан. Кембриж сургалтын системийг дунд сургуульд туршилтын журмаар нэвтрүүлж эхэлсэн билээ. Гэвч хүнд суртал, сургалтын хязгаарлагдмал орчин шүдний өвчин болсоор...

Боловсролын салбарт тулгарч буй хамгийн том хүндрэл бол их, дээд сургуулиудын сургалтын системийн асуудал юм. Нэгдүгээрт, дэлхийн жишигт нийцсэн мэдлэг, боловсролтой багш бараг үгүй гэж болно. Учир нь, тэдний мэдлэгийн түвшин дунд сургуулийн сурган хүмүүжүүлэгчийнхээс нэг их гавих нь юу л бол. Хэдхэн сарын өмнө оюутан насаа үдсэн залуусын ирээдүй нь “бүрхэг” байгааг тэд дуу нэгтэй хэлж байлаа. Төсгөх жилдээ суралцаж буй оюутнууд ч өөр чиглэлээр гаднын их, дээд сургуулиудад суралцах сонирхолтой байгаагаа илэрхийлж байсан юм.

Уул уурхайн салбар залууст хэмжээлшгүй их боломжийг олгож буй мэт төсөөлөл газар авсаар байна. Учир нь, Монгол Улсын өнөөгийн хөгжлийн хөдөлгүүр болсон уул уурхайн салбар тэдэнд өндөр цалин амлахын зэрэгцээ мэдлэг, чадвараа дээшлүүлэх цорын ганц гарц гэх ойлголтыг түгээж байна.

Эх орондоо боловсрол эзэмшсэн тэдгээр залуус амьдрал, ажлын талбарт бэлэн бус байгаа нь өдөр ирэх тусам ил болж байна. Эдийн засгийн бодлого, өрсөлдөх чадвар судалгааны төвийн ерөнхий захирал Ч.Отгочулуугийн хэлснээр асуудлын үндэс бага ангиас эхэлдэг аж. Ерөнхий боловсролын сургуулиуд баяр андахгүй амардаг байдал сурагчдад хичээлийн хоцрогдол үүсгэх нэг шалтгаан болж байна гэж шүүмжлэв. Тэрбээр “Сурагч, оюутнуудын хувьд арванхоёрдугаар сараас баяр, ёслол салахаа байдаг. Ингээд бодохоор тэдэнд нэг хичээлийн жилд ердөө гурваас дөрвөн сар л суралцах хугацаа байдаг гэж болно” гэв. Бэл бэнчинтэй нь хүүхдээ төлбөр өндөртэй хувийн сургуульд сурган их сургуулийн боловсролыг гадаад орнуудад эзэмшүүлдэг. Монголын Засгийн газраас тэтгэлэгт сургалт зарладаг боловч түүнд хамрагдсан хүмүүсийн нэрсийг нууцалдаг тул бага, дунд орлоготой оюутнууд хамрагдаж чаддаг эсэх нь тодорхойгүй.

Кембрижийн сургалтын системийг нэвтрүүлснээр дээрх асуудлыг залруулна хэмээн Засгийн газар найдаж байлаа. Гэвч Нээлттэй нийгэм, боловсролыг дэмжих хөтөлбөрийн ахлах менежер Кейт Лафамын Euraiantet.com цахим хуудаст нийтэлснээр нэг хэсэг нь нөгөөгөөсөө илүү боломжийг хүртсээр байх аж. Тэрбээр “Элсэлтийн шалгалтын дүн зэрэг өчүүхэн зүйлээр оюутнуудыг сонгон эрэмбэлэх нь нийгмийн эрх тэгш байдлыг алдагдуулдаг. Ядуу гэр бүлээс гаралтай, хөдөө, орон нутагт амьдардаг эсвэл хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд суралцах орчин, сурч боловсрох боломж хомс байгаа нь тэдний ирээдүйгээ харахитгэлийг хугасалж байна” хэмээн нийтлэлдээ бичжээ. Сургууль нэмж барих нь асуудлаас ангижрах гарц биш.



Ингэхийн зэрэгцээ багш, сурган хүмүүжүүлэгчдийн цалин, ур чадвар, мэдлэгийг нэмэгдүүлэхээс гадна сургалтын орчинг бүрдүүдэхэд анхаарах нь чухал. Лафамын хэлж буйгаар “элит” гэгдэх төлбөр нь тэнгэрт тулсан сургуулиуд барихын оронд хэдийнэ үүд хаалгаа нээсэн сургуулиуддаа эрх тэгш байдлыг чандлан сахиулах хэрэгтэй буй за. Боловсролын яамнаас өнгөрсөн жил нэвтрүүлсэн систем “элит сурагчдад” элит болох боломжийг нээж өгөх хаалга болж байгаа нь тус систем зорилтот хамрах хүрээгээ буруу сонгосон мэт санагдана.

Мөрөөдөх үү, мөрдөх үү

Ч.Отгочулуугийн үзэж буйгаар Монгол Улсын боловсролын системийг сайжруулах нь биелэшгүй мөрөөдөл. Харин үүний оронд оюутнуудад гаднын оронд боловсрол эзэмшихэд нь түлхэц болох нь илүү үр дүнтэй аж. Гэвч ингэснээр чадварлаг ажиллах хүчнээ алдах эрсдэлийг дагуулж болохыг тэрбээр дурдсан юм. Гадаад оронд суралцаж төгссөн оюутнууд өөрсдийн мэдлэг чадвараа эх орондоо бус суралцсан тухайн улсдаа ашиглах сонирхолтой байдаг. Түүнчлэн оюутнууд зөвхөн Америк, Европын орнуудаар хязгаарлагдахгүй өөр оронд суралцах боломжийг хайх хэрэгтэй аж. ОХУ, Казахстан, Унгар зэрэг орны боловсролын чанар дээрх орнуудаас доогуур боловч оюутнуудын эх орондоо буцаж ирэх магадлал нь илүү өндөр аж.

Асуудлын өөр нэг тал бол практик. Хэдийгээр залуус ▶

► эх орондоо эзэмшсэн боловсролдоо сэтгэл хангалуун байдаг ч мэдлэгээ практикт хэрэгжүүлдэг нь цөөн. Mongolian Talent Network-ийн ажилтан Томас Янгман “Ажилд орох хүсэлтэй залуусын онолын мэдлэг чамлахааргүй, харин түүнийгээ практикт хэрэгжүүлсэн цаг нь хангалтгүй байдаг. Тэд бакалавр цаашлаад магистрын түвшний мэдлэгтэй байлаа гээд практик үгүй бол туршлага бага гэсэн үг. Бизнесийн удирдлагын дипломтой бүхэн бизнесийг удирдах чадвартай байдаггүй” хэмээн онцолсон юм. Түүнчлэн эцэг, эхчүүд хүүхдүүдээ ямар мэргэжил сонгохыг тулган шаарддаг тул дийлэнх оюутан амьдралынх нь сонголт буруу байсныг сүүлд ухаардаг. Янгманы хэлснээр залуусын өөрсдийн сонгосон мэргэжил тэдний төсөөллөөс өөр болоод ирэхээр ондоо зүйл сонирхох нь элбэг байдаг аж.

Төгсөх курсын оюутнуудын дийлэнх нь ажил хайхаас илүүтэйгээр дахин суралцах хүсэлтэй байна. Барууны томоохон байгууллагуудад ажилд орохын тулд эрдмийн зэрэг, цолтой байх шаардлагатай байдаг. Харин Монголд тэр дундаа хөдөө орон нутагт эрдмийн зэрэг шаардах нь ховор.

Санхүү, бизнесийн чиглэлээр боловсрол эзэмшсэн залууст ажлын туршлага хуримтлуулах боломжийг олгодог компани бол Монголын хөрөнгө оруулалтын корпораци юм. Тус байгууллагыг санхүүгийн зах зээлийн ертөнцөд хөл тавих гэж буй залууст дагалдан суралцаж туршлага хуримтлуулах “анхны тусламжийг” үзүүлдэг гэж хэл болно. Нью -Йорк хотын “Columbia” их сургуулийг төгссөн Д. Ачит-Эрдэнэ захирал гадаад, дотоодын сургууль төгссөн эсэхээс үл хамааран оюутан, залуусын чадварт үнэлэлт, дүгнэлт өгдөг нэгэн билээ. Тэрбээр “Би гадаад, дотоодын сургууль төгсөгчдийн холимог байдлыг ирэлхийлэхийг хүсдэг. Учир нь тэдний аливаад хандах хандлага өөр өөр байдаг. Монголд санхүү, бизнесийн боловсрол эзэмшсэн залуус дотоодын эдийн засгийг илүү мэддэгээрээ давуу талтай. Харин гадаадад төгсөөд ирсэн залуус хэлний мэдлэг сайтай байхын зэрэгцээ бичих, илтгэх чадварыг илүү эзэмшсэн байдаг” хэмээн хэлсэн юм.

Дипломтой ажилгүйчүүдийн өөр нэг асуудал бол нэр төр. “Тэд хамгийн шилдэг, хамгийн сонирхолтой ажил хийхийг эрмэлздэг” хэмээн Отгочулуу өгүүллээ. Ажил олгогчдын шаардлагыг бэлтгэгдэн гарч буй ажиллах хүчин нь хангахгүй байгаад гол учир байгаа аж. Иймээс мэргэжилтэй ажилгүйчүүдийн тоо нэмэгдсээр байгаа юм. Тэрбээр “Энэ бүхэн нэр төртэй шууд холбоотой. Хэн ч үйлдвэрийн ажилчин байхыг хүсдэггүй. Тэд бүгд эмч эсвэл хуульч болохыг зорьдог. Гэвч эдийн засаг үүнийг барьж дийлэхгүй” гэв.

Монголд ямар боловсон хүчин дутагдалтай байгаа талаар Ачит-Эрдэнэ захирлаас асуухад санхүү, нягтлан бодох, уул уурхайн инженер болон геологийн мэргэжилтнүүд дутмаг байгааг онцоллоо. Тэрбээр “Би хувьдаа чөлөөт уран бүтээлчдийг ажилд авах дуртай. Учир нь, тэд илүү нээлттэй сэтгэж аливааг сурахдаа хурдан байдаг. Түүнчлэн тэдэнд өөрийгөө илэрхийлэх онцгой чадвар илэрдэг. Энэ нь хөрөнгө оруулалтын салбарынханд байх хамгийн чухал чанар” гэсэн юм. ■

Ажилд орох нь...

Mongolian Talent Network байгууллагын ажилтан Томас Янгман Монголын зуу зуун залууг ажлын байртай болох замд нь хөтөлсөн нэгэн. Түүний хэлснээр сургуулиа дөнгөж төгссөн залуус хүссэн мэргэжлээрээ ажиллах, ажлын ярилцлагад хэрхэн бэлдэх талаар мэдлэг дутмаг байдгаас ажил олгогчдын анхааралд өртдөггүй аж.

Ажил хайж буй залууст зориулсан түүний зөвлөгөө:

Өөрт байгаа боломжийг ашигла: Ажилд ороход анхаарах зүйлс, анкет хэрхэн бөглөх гээд интернэтэд олон зөвлөгөө байдаг. Тэр бүхнийг зөв ашиглах нь ажилд орох эхний ахлхам байж болох юм.

Тусгайлан анхаарах зүйлс:

Анкет буюу CV (curriculum vitae)-г нэг хуудаснаас хэтрүүлж болохгүй гэдгийг санах хэрэгтэй гэдэг. Харин Томас Янгманы хэлснээр уг дүрмийг умартаад өөрийн мэдээллийг аль болох дэлгэрэнгүй тусгах нь зөв аж.

Ажлын байрандаа тохируулан CV-гээ бөглөх:

CV бүр өөрийн гэсэн тодорхой загвартай байхын зэрэгцээ ажлын байрны саналтай уялдуулан CV-гээ бичих нь чухал.

Харилцаа үүсгэ:

Нэрийн хуудас солилцох нь харилцаа үүсгэх нэг хэрэглүүр. Харин нэрийн хуудас солилцсон хүнтэйгээ холбоо барихгүй байх нь хүмүүсийн гаргадаг нийтлэг алдаа болохыг Янгман сануулсан юм. Мөн хэн нэгэнд нэрийн хуудсаа өгөхдөө өөрийгөө товчхон танилцуулах нь илүү үр дүнтэй байдаг аж.

Ярилцлагад бэлд:

Ажилд орох ярилцлагад бэлдээгүйн улмаас “хар нүхэнд” унах нь элбэг. Тиймээс ярилцлагад очихын өмнө найз, нөхөдтэйгөө хамтран сайтар бэлдэх хэрэгтэй. Ярилцлагын нийтлэг асуултуудыг интернэтээс хялбархан олох боломжтой. Янгман “Сандарч байна гэдэг нь хангалттай бэлтгэл хийгээгүй, асуултад хэрхэн хариулахаа мэдэхгүй байна гэсэн үг” гэв.

Монголчууд баярхах дургүй ард түмэн. Харин ярилцлагын үеэр өчүүхэн ч гэсэн баярхах нь гэмгүй болохыг Янгман зөвлөсөн юм.

ТЭД БИДНИЙ ТУХАЙ

МОНГОЛЫН БАЯЛАГ БОЛОВСРОЛЫН БОЛОМЖИЙГ ХЯЗГААРЛАХ ЁСГҮЙ

Монголд хийгдэх гэж буй боловсролын салбарын шинэчлэлтэй холбогдуулан EurasiaNet.org цахим хуудаст энэ оны гуравдугаар сарын 8-нд энэ нийтлэлийг тавьжээ. Нью-Йорк хотноо төвтэй EurasiaNet.org нь Баруун Өмнөд Ази, Орос, Турк, Төв Ази болон Кавказ зэрэг улсын нийгэм, эдийн засаг, улс төр, байгаль орчны талаар дагнан бичдэг аж.

Б.ЭНХЦЭЦЭГ

Монгол Улс саяхнаас боловсруулж мэхэлсэн эрдэс баялгийнхаа багагүй хэсгийг нийгмийн үйлчилгээнд шинэчлэл хийхэд зориулахаар болжээ. Засгийн газар нь алс ирээдүйгээ харж байгаа нь сайшаалтай ч уудам агаад алслагдмал энэ оронд иргэдийн олонхийг хамарсан өөрчлөлт авчирч чадах уу гэдэг томоохон сорилт. Тус улсын хүн амын бүтцийн онцлог тухайлбал, нийслэл хот Улаанбаатартаа хэт их төвлөрсөн байдаг нь сургууль соёлын асуудалд багагүй бэрхшээл учруулдаг. Гэсэн ч өргөн уудам нутагт таран суурьшсан цөөн хүн амыг ч сургах л ёстой.

Монгол Улсын боловсролын шинэчлэл хийх арга зам нь Азийн өөр нэгэн байгалийн арвин нөөцтэй орон болох Казахстан улсын хүчин чармайлттай нэлээд төстэй. Тус хоёр улс хоёулаа нэр хүндтэй Кембрижийн их сургуультай хамтран их, дээд сургуульд хамгийн чадварлаг оюутнуудыг бэлтгэх элит ерөнхий боловсролын сургуулиудын сүлжээг бус, орон нутгийн төвүүдэд болон нийслэл хотод хөгжүүлэхээр ажиллаж байгаа юм байна. Янз нь хөгжиж буй орнууд дахь сор болсон шилдгүүдтэй богино хугацаанд хөл нийлүүлэхийг зорьж байгаа бололтой. Үүнийг боловсролын систем дэх өнгөц маягийн европ шинэчлэл гэж хэлж болно. Эдгээр улс нь Кембрижийн зөвлөхүүдээр дамжуулан багшлах арга

барилыг хөгжүүлж, цаашид ерөнхий боловсролын систем дэх үлдсэн хэсгийг бага багаар чирэх бодлыг өвөртөлж байгаа хэрэг юм.

Гэвч одоогийн боловсролын яаманд ч дутаж буй нэгдмэл зүтгэл, харилцан уялдаатай төлөвлөгөө байхгүй нь бодлогын шинэчлэлийг алхам ч ахиулахгүй нь ойлгомжтой. Засгийн газар шинэ сургууль барих, бүрэн тохижилт хийх, одоогийн дэд бүтцийг шинэчлэх мөн багш нарыг сургах тал дээр шаардлагатай нөөц бололцоогоо бүрэн ашиглахад бэлэн байх ёстой. Тухайлбал, элит сургуулийн нэг ангид дээд тал нь 25 сурагч байхаас гадна мэргэжлийн болоод туслах багш байх хэрэгтэй. Харин өнөөдрийн байдлаар, Улаанбаатар хотын ердийн нэг сургуульд туслах багш ч байхгүй мөртлөө 40-өөс дээш сурагчид ганц багш ногддог. Хэрэв ердийн сургуулиудын багш нар ч мөн адил энэхүү хөтөлбөрийг дагаж мөрдөх үүднээс нэмэлт сургалтад хамрагдах юм бол тэдгээр багшид цөөхөн хүүхэдтэй ангид зориулагдсан энэхүү стратегийг амьдрал дээр хэрэгжүүлэхэд багагүй саад учрах болов уу.

Боловсролын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Улаанбаатар хот дахь төрийн бус байгууллагуудын санаагулсын сургуулиудад хангалттай санхүүжилт байдаггүй, багш нар чамламаар цалин авдаг, сургуулиуд болон





Фотог Б.Бямба-Очир

▸ дотуур байрны хүрэлцээ байхгүй мөн олон мянган хүүхэд сургуульд сурдаггүй гэх мэт асуудал зовоодог. Тэдний зүгээс шинэ элит сургуулиудад Кембрижийн программд шилжихэд шаардагдах асар их хөрөнгө оруулалт улсын сургуулиудад очих боломж нөөцийг өөр зүгт залах вий гэдгээс ихээхэн эмээж сууна.

Түүнчлэн ядуу амьдралтай болон сургуулийн өмнөх боловсрол эзэмших боломжгүй алс бөглүү газрын хүүхдүүд мөн хэлний мэдлэг тааруу, тахир дутуу хүүхдүүдэд боломж хомс төдийгүй элит сургуулиудад элсэх шалгалт өгөх ямар ч боломжгүй гэдэг нь тодорхой юм.

Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн OECD байгууллагын гаргасан судалгаагаар эрх тэгш байдлыг маш сайн хангаж чадсан боловсролын системтэй орнууд ялгаварлан ангилахаас илүүтэйгээр бүх хүүхдэд ижил хэмжээнд, өндөр хүртээмжтэй системийг бий болгож чадсанд оршдог. Хэрэв Монголын боловсролын шинэчлэл БШУЯ-ныхны амлаж байгаачлан хөгжил дэвшил, нэгдмэл байдалд хүрэхээр зорьж байгаа юм бол бодлого, боломжоо цөөн элит хэсэгт бус нийтэд, тэр дундаа ядууст чиглүүлэх нь зүйтэй юм. ■

ТАЙ ЛАН

ДЭЭД БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ МОНГОЛД

Дэлхийн банкнаас Зүүн Ази, Номхон далайн бүсийн дээд боловсролын тогтолцоог хөдөлмөрийн зах зээлийн эргэлт ба эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагатай уялдуулах нь гэсэн тайланг 2011 оны аравдугаар сард танилцуулсан билээ. Бодлогын шинжтэй зорилтуудыг гаргаж тавьсан уг тайлангийн хураангуйг шинэ Парламент, шинэ Засгийн газрын гишүүдийн сонорт хүргэж байна.

Монгол Улсын хөгжилд дээд боловсрол цаашид илүү их хувь нэмэр оруулах боломжтой

Монгол Улсыг ирэх арван жилийн хугацаанд эдийн засгийн хамгийн хурдацтай өсөлттэй улс орон болно хэмээн үзэж байгаа ч бүтээмж дээшлүүлэхгүйгээр эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, орлогыг шат дараалан нэмэгдүүлэх нь ихээхэн хүндрэлтэй асуудал байх болно. Бүтээмжийг дээшлүүлэх хоёр гол хүчин зүйл болох ур чадвар болон орчин цагийн технологийг нэврүүлэх, шинэчлэхэд чиглэсэн судалгааг хөгжүүлэхэд дээд боловсрол чухал үүрэг гүйцэтгэдэг. Энэ утгаараа дээд боловсрол нь хөгжлийн нэг гол хөдөлгөгч хүч мөн. Дээд боловсрол эзэмшсэн иргэдийг дээд боловсролгүй иргэдтэй харьцуулахад ур чадварын түвшингээрээ илүү байдаг. Мөн сурах, техник мэргэжлийн, сэтгэн бодох ур чадвар нь ажлын бүтээмжид эерэгээр нөлөөлдөг гэдэг нь судалгаагаар батлагдсан. Шинэчлэлийн хэд хэдэн үзүүлэлтийг харахад дээд боловсролын хэрэгцээ, шаардлагыг онцолсон байдаг. Нийт ажилчдын дунд 12-оос дээш жилийн боловсролтой ажилчдын эзлэх хувь 25 хувиар нэмэгдэхэд тухайн байгууллагын шинэлэг бүтээлч байдал нэмэгддэг гэсэн тооцоо байдаг. Шинжлэх ухааны салбар, инженерийн чиглэлээр дээд боловсрол илүүтэй олгосон, мөн дээд боловсролын судалгааг сайн хөгжүүлсэн улс орнууд илүү шинийг санаачлагч улс орон болж чаддаг байна.

Дээд боловсролын чанарын доголдол нь зах зээл дэх ур чадварын хэрэгцээг хангаж чадахгүйд хүргэж байна

Ажил олгогчид нь ажилтнуудаасаа бүтээмж, өсөлтийг дэмжихүйц техникийн, арга барилын болон сэтгэн бодох ур чадварыг хүлээж байдаг. Тэдэнд ихэвчлэн шинжлэх

ухаан, технологи, инженер, математикийн чиглэлээр мэргэшсэн хүмүүс шаардагддаг. Мөн түүнчлэн, өндөр хэмжээний нэмүү өртөг бий болгох аж үйлдвэрлэлийн салбар болон өндөр бүтээмж бүхий үйлчилгээний салбарт асуудал шийдвэрлэх, бүтээлч сэтгэлгээ, бизнесийн, харилцааны ур чадвар ихээхэн шаарддаг.

Монгол Улсын зах зээлд нийлүүлж буй дээд боловсролтой төгсөгчдийн тоо нь энэ бүс нутгийн бусад орнуудтай харьцуулахад өндөр байдаг боловч дээд боловсрол эзэмшигчдийн ур чадвар дутмаг байгааг хэд хэдэн үзүүлэлтээс харж болно. Ажилгүйдлийн хэмжээ нэлээд өндөр боловч үүнтэй зэрэгцээд зарим мэргэжлийн ажлын байранд тохирох мэргэжилтэн олж авахад ихээхэн (бараг зургаан долоо хоног) цаг хугацаа шаарддаг байна. Энэ нь төгсөгчид ажил олгогчдын хүсэн хүлээж байгаа ур чадварыг бүрэн эзэмшээгүй байгааг зарим талаар харуулж байна. Энэ байдал нь хязгаарлагдмал чиглэлээр мэргэжилтэн бэлтгэдэг дээд боловсролын тогтолцоо (ялангуяа техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагууд дутмаг) байдагтай мөн холбоотой. Ажил олгогчид ба ажилтнуудын зүгээс англи хэлний мэдлэг, манлайлах ур чадвар, харилцааны ур чадвар дутмаг байгаа талаар ихээхэн санал гардаг. Ялангуяа, уул уурхай, дэд бүтэц, аж үйлдвэрийн салбарт технологи, инженерийн чиглэлийн ур чадварын хангагдаагүй хэрэгцээ өндөр, хүссэн мэргэжилтнийг олж авахад хүндрэлтэй хэвээр байна. Түүнчлэн, их дээд сургуулийн оюутнуудын хувьд өргөн хүрээний мэдлэг, мэдээллийг олж авах, бүтээлчээр сэтгэх болон өөрийгөө байнга хөгжүүлэх чадварт суралцах, бусадтай харилцах чадвар эзэмших, өөрийн ирээдүйн кариерийн эхлэлийг бүтээлчээр тавих гэх мэт ур чадварыг тэр бүр бүрэн эзэмшиж чадалгүй төгсөж байна. ▶

¹Бүрэн дунд сургуулиас дээшхи шатны, төрийн болон хувийн өмчийн боловсролын байгууллагуудыг хамруулсан өргөн ойлголт.

²1992 онд 20,000 орчим оюутан дээд боловсролын байгууллагад суралцаж байсан бол энэ тоо 2007 онд 149,915 болж бараг найм дахин өссөн байна.



Фотог Э.Зоригт

▶ Монгол Улсын их дээд сургуулиудын судалгааны ажил маш хязгаарлагдмал

Дээд боловсролын байгууллагын нэг чиг үүрэг бол нийгэмд шинэ санаачилгыг нэвтрүүлэхэд түлхэц өгөх судалгаа, шинжилгээний ажлыг хөгжүүлэх явдал юм. Их сургуулиуд бизнесийн салбарт шинэ санааг түгээх, суурь ба сэдэвчилсэн судалгаа, технологи шилжүүлэх замаар мэдлэгийн болон технологийн шинэчлэлд чухал үүрэг гүйцэтгэх боломжтой байдаг ч Монгол Улсын дээд боловсролын байгууллагууд чанарын зохих шаардлагыг хангасан судалгаа хийх түвшинд хүрээгүй байна. Технологийн шинэчлэл, өөрчлөлтөд их сургуулиудын оролцоо хязгаарлагдмал байна. Аж ахуйн нэгжүүдэд хийсэн судалгаанд оролцсон байгууллагуудын зөвхөн 1-2 хувь нь технологийн шинэчлэл хийхэд (өргөн утгаар) их сургуулиуд тэргүүлэх үүрэгтэй гэж тэмдэглэсэн байна. Монгол Улсын их дээд сургуулийн багш нарын дунд докторын зэрэг тэй багшийн эзлэх хувь бага, мөн тэдний ихэнхийнх нь үндсэн чиг үүрэг нь судалгаа шинжилгээний ажил бус хичээл заах ажил байдаг. Энэ нь бас их сургуулийн багш нарын ачаалал их, нэг багшид ногдох оюутны тоо олон байдагтай холбоотой юм. Тиймээс, цаашид Монгол Улсын их, дээд сургуулиуд нь мэргэжилтэн бэлтгэхийн хажуугаар судалгаа, технологиор дамжуулан нийгэмд шинэ санаа, санаачилгыг дэмжих тал дээр түлхүү ажиллах шаардлагатай.

Бодлогын тэргүүн зорилтууд

Монгол Улс эдийн засгийн хурдацтай өсөлт, технологийн тасралтгүй дэвшлийг хангахад дараах хоёр зорилтыг хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

- Дээд боловсролын чанарыг сайжруулах замаар зах зээлд шаардлагатай ур чадварын хэрэгцээг хангах, дээд боловсролын тоон ба чанарын үзүүлэлтийн тэнцвэрийг хангах,
 - Эдийн засгийн хөгжлийн хэрэгцээ шаардлагатай уялдуулан зарим их сургууль, тэнхимийн судалгааны чадавхыг бэхжүүлэх ажлыг эхлүүлэх,
- Монгол Улсын Засгийн газрын бодлогын хүрээнд эдгээр зорилтуудыг хэрэгжүүлэхийн тулд дараах ажлыг зохион байгуулах боломжтой. Үүнд:
- Их, дээд боловсролын байгууллагууд, тэдгээрийн удирдлагын бие даасан байдлыг хангах үйл явцыг бүрэн хийх;
 - Дээд боловсролын зэрэгцээ техник мэргэжлийн боловсролын сургалтыг бэхжүүлэх;
 - Хувийн их, дээд сургуулийн чанарыг сайжруулах илүү хүчтэй хөшүүрэг бий болгох;
 - Шинжлэх ухаан, технологи, инженер, математикийн чиглэлд оруулах улсын төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлэх;
 - Судалгаа шинжилгээнд зориулах төсвийн зарцуулалтыг нэмэгдүүлэх, ашиглалтыг илүү оновчтой болгох;
 - Зарим их сургууль-үйлдвэрлэлийн холбоог дэмжих замаар сургалтын хөтөлбөрийг салбарын хэрэгцээ шаардлагатай уялдуулж, технологийн хөгжилд дээд боловсролын байгууллагын оролцоог нэмэгдүүлэх. ■

Уг тайланг татах, илүү мэдээлэл авахыг хүсвэл дараах веб сайтад хандана уу: www.worldbank.org/eap/highered

ИМФЛЯЦИ

ИНФЛЯЦЫН БУУРАЛТЫГ БОЛОВСРОЛЫН САЛБАР ХАДГАЛЖ ЧАДАХ УУ

Зах зээлийн эмзэг байдал, Засгийн газрын тодорхойгүй байдлыг овжин ашиглах гэсэн их, дээд сургуулийн зарим өөдгүй захирлын санаархалд БШУ-ны сайд Л.Гантөмөр мэдрэмжтэй хандав уу гэлтэй.

Б.САНЖААХАНД

Үндэсний статистикийн хорооноос гаргадаг сар тутмын нийгэм, эдийн засгийн өнгийг “шинжсэн” статистик мэдээллийн өнгөрөгч наймдугаар сарынх чихэнд чимэгтэй мэдээ байлаа. Учир нь, улсын хэмжээнд 17 хувьд хүрч гаараад байсан инфляци 14.5 хувьтай гарчээ. Өмнөх сартай нь харьцуулахад 0.6 хувиар өссөн ч инфляци нийт дүнгээрээ ийн буурсан үзүүлэлттэй гарсан нь сайн хэрэг. Харин цойлсон инфляци гэнэт уурганд орсон шалтгаан юу байв, цаашид энэ байдал хэр удаан хадгалагдах бол гэдэг хүн бүрийн сонирхлыг татах нь мэдээж. Тэгвэл инфляци хазаарлагдсан шалтгаан нь хэрэглээний үнийн сагсанд буй хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь хэмжээнд өөрчлөлт орсонтой холбоотой гэнэ. “Хэрэв хэрэглээний сагсанд өөрчлөлт ороогүй бол инфляцын түвшин одоогийнхоос ч өндөр байх байлаа” гэж Монголбанкны дэд ерөнхийлөгч Н.Золжаргал тэмдэглэсэн. Харин хэрэглээний үнийн сагсанд орсон өөрчлөлтийн талаар ҮСХ-ны Макро эдийн засгийн Статистикийн газрын дарга Б.Бадамцэцэг хэлэхдээ “Улсын хөгжлийн түвшинг дагаад Монголын хэрэглээний үнийн индекс тээлж буй хүнсний бараа бүтээгдэхүүний хувь буурсан. Өөрөөр хэлбэл, иргэдийн амьжиргааны түвшин дээшилж, хоол хүнсэндээ нийт орлогынхоо 40 хувийг зарцуулдаг байсан бол одоо 30 хуви

зарцуулдаг болсонтой холбоотой. Энэ нь өрхийн хэрэглээний бүтэц өөрчлөгдсөн гэсэн үг” хэмээн тайлбарлалаа. Нэг үгээр хэлбэл, хэрэглээний үнийн сагсанд хүнсний бүтээгдэхүүний эзлэх хувь буурсаныг зүй ёсны зүйл буюу хөгжлийн хэмжүүр гэж холбогдох албаныхан үзэж байна.

Сайн байна, сайн байна. Эдийн засгийг хадны мангаа мэт айлгах

Инфляцын өнөөдрийн түвшин он дуустал хадгалагдах төлөв бий. Гэвч махны ханш, их, дээд сургуулийн сургалтын төлбөр томоохон хүлээлт үүсгээд байгааг санхүүгийн шинжээчид онцолж буй. Хэдий инфляцын тухайд эерэг хүлээлт байгаа ч дээрх хоёр төрлийн бараа, үйлчилгээний ханш хэр тогтохоос луу жилийн сүүлчийн хагасын эдийн засгийн өнгө тодорхойлогдох болчихоод байна.

инфляцийн өсөлт ногтлогдож л байвал улсын нийгмийн болоод хувь хүний амьдралд нэмэртэй. Харин инфляцийн цаашдын төлөв хандлага ямар байхыг санхүүгийн мэргэжилтэн, шинжээчид анзаарч, ажиглаж суудаг. Тийм болохоор энэ талаар Монголын санхүүгийн зах зээлийн холбооны

Сургалтын асуудал хариуцсан дарга Л.Бямбаагаас лавлалаа. Тэрбээр “Инфляцын өнөөдрийн түвшин он дуустал хадгалагдах төлөв бий. Гэвч махны ханш, их, дээд сургуулийн сургалтын төлбөр томоохон хүлээлт үүсгээд байгаа” гэсэн юм. Хэдий инфляцийн тухайд эерэг хүлээлт байгаа ч дээрх хоёр төрлийн бараа, үйлчилгээний ханш хэр тогтохоос луу жилийн сүүлчийн хагасын өнгө тодорхойлогдох болчихоод байна. Тийм болохоор малчид, махны худалдаа эрхлэгчид, их, дээд сургуулийн удирдлагуудад хандаж, “Инфляцын эерэг хүлээлт зөвхөн та нарын гарт байна шүү” гэж өндөр дуугаар дуулгамаар санагдана.

Хүсэхээр хясна гэдэгчлэн инфляци буурах хандлагыг хадгалахгүй гэсэн шиг их, дээд сургуулиудын зүгээс 2012-2013 оны хичээлийн шинэ жилийн сургалтын төлбөрийг өмнө нь байгаагүй өндөр хувиар нэмэхээр зэхэж, оюутан сурагчдыг сандаргаж байгаа нь харамсалтай. Өнөөдрийн байдлаар (2012.08.30) сургалтын төлбөр харахан тодорхой болоогүй ч төрийн өмчит их, дээд сургуулиудын удирдлагууд 10, 20 биш бүр 30, 40 хувь нэмэх сэмхэн тушаал шийдвэр гаргаж зэхсэн нь инээдэмтэй. Сүүлийн жилүүдэд боловсролын чанарыг умартаж, мөнгөний авдар болгож хувиргасан захирлуудад оюутнаас их мөнгө авах нь сайхан л байх. Харин “Өөдөө шидсэн чулуу өөрийн толгой ▶


«дээр» гэгчээр, өөрийнх нь шударга бус үйлдэл нь эргээд инфляцыг өдөөж, сургуульдаа авах бараа, үйлчилгээ өндөр үнэтэй болж, эцсийн дүнд бизнес нь инфляцид идэгдэнэ гэдэг энгийн зүйлийг мэддэггүй л юм байх даа, хөөрхий.

Харин зах зээлийн эмзэг байдал, Засгийн газрын тодорхойгүй байдлыг овжин ашиглах гэсэн их, дээд сургуулийн зарим өөдгүй захирлын санаархалд БШУ-ны сайд Л.Гантөмөр мэдрэмжтэй хандав уу гэлтэй. Тэрбээр өнгөрсөн сарын 23-нд төрийн өмчийн их, дээд сургууль, коллежийн захирал нарт хандан “2012-2013 оны хичээлийн шинэ жилийн сургалтын төлбөрийн хэмжээг тогтоохдоо инфляцын түвшинг харгалзан 10 хувиас илүү нэмэхгүй байхыг мэдэгдэж байна. Түүнчлэн сургалтын төлбөрийг оюутны боломжид тулгуурлан хэсэгчлэн улирал, сараар авах, энэ талаар оюутнуудтай байгуулах гэрээ хэлэлцээрт онцгойлон тусгах зэрэг арга хэмжээ авч, эцэг эх, суралцагчдад дарамт учруулахгүйгээр үйл ажиллагаа явуулахыг анхааруулж байна” гэж цагаан дээр хараар бичсэн үүрэг чиглэлийг өгсөн байна. Тэрбээр зарим их, дээд сургуулийн захирлуудтай уулзаж, үүрэг чиглэлээ танилцуулсан. Гэвч цээжний тооцоо хийж, сайхан зүйл бодсон захирлуудад энэ нь аянг буух мэт санагдаа биз ээ. Тийм ч учраас өнгөрсөн сарын 23-нд гарсан тушаалын дагуу гурваас дөрөв хоногийн дараа их, дээд сургуулиудын зүгээс холбогдох газарт зөвшөөрч буйгаа илтгэсэн эцсийн хариуг дуулгах байсан ч нэлээд хэд хоногоор сунжирсаар. Их, дээд сургуулийн удирдлагууд төлбөрөө 30-аас дээш хувь нэмэх бодолтой байгаагаа багш нарын цалинг нэмэгдүүлнэ. Сургалтын орчин нөхцөл, бааз суурийг нэмэгдүүлж, сургалтын чанарыг сайжруулна” гэсэн тайлбараар арьсаа хамгаалж байгаа нь ч утгагүй юм. Өнгөрсөн 20-иод жилд их, дээд сургуулийн сургалтын төлбөр байнга л нэмэгдэж ирсэн. Ерээд оны сүүлчээр дунджаар жилийн 200,000 төгрөгийн үнэтэй байсан хувийн болоод хувьсгалын их, дээд сургуулийн сургалтын төлбөрийн

зарим нь өдгөө 2.0 сая орчим төгрөгт хүртлээ өсөөд байгааг юу гэж хэлэх гэсэн юм бол. Энэ хугацаанд оюутан, сурагчдаас авсан мөнгөөрөө багш, ажилчдынхаа цалинг нэмж, сургалтын бааз сууриа бэхжүүлэхэд зарцуулдаггүй байсан хэрэг үү. Гэнэт сэрсэн мэт сургалтын чанарт анхаарахын тулд төлбөрөө огцом нэмэхээс аргагүй гэж ярьж байгаа нь инээдтэй хэрэг. Харин хувийн их, дээд сургууль үнэ ханшаа тогтоохдоо улсын сургуулиудын жишгийг харгалздаг уламжлалтай. Тэгвэл энэ жил улсын сургуулиуд дээрээс авсан үүрэг чиглэлийнхээ дагуу үг хэлээ нэгтгэж, нэгдсэн шийдэлд хүрэх гэж удаж байгаа учраас боловсролын салбарт ханшийн хүлээлт бий болжээ. Хүлээлт гэхдээ хичээл цуглах үед тодорхой болох нь мэдээж. Түүнчлэн бусдыг харгалзахгүйгээр үнээ толгой мэдэж

тогтоосон их, дээд ч гэлтгүй хувийн бага, дунд сургууль ч бий дуулдав. Хувийн сургуульд төр дээрээс үүрэгдэх нь утгагүй. Гэхдээ цаг үеийн мэдрэмжтэй, зах зээлд захирагддаг баймаар. Тэгээгүйгээс, ялангуяа хувийн хэвшил тэр дундаа бизнесийн салбарт ойд ганцаараа амьдардаг сармагчин мэт зан гаргаснаас үүдэн эдийн засагт ханшийн хөөрөгдлийг өдөөж, бусдыг хөлдөө чирэх нь бий. Түүнчлэн махны ханш имфляцид ахиу жин дардаг. Гэхдээ Үндэсний статистикийн хорооны шинэ мэдээллээс харахад, өнгөрөгч сарын 29-ний байдлаар махны үнэ харьцангуй тогтвортой байна.

Мөн шинжээчид хойд хөрш энэ намар ургац арвин авах боломж тааруу төлөв буй нь Монголд инфляцын өсөлтийг дахин өдөөхийг үгүйсгэхгүй байгаа юм. ■





ОЮУТОЛГОЙН БУЛАН

ШИНЭ САЛХИ

Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь тус компанийн үйл ажиллагааг хэмжих хэмжүүр аж.

Б.ТОГТОХ

Энэхүү цуврал нийтлэлээр дамжуулан говийн байгаль орчин, нөхөн сэргээлт, орон нутгийн өнөөгийн хөгжлийн төрх байдлыг онцлов.

Уулын баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрээс дөрөв дахин том “Оюутолгой” төслийн бүтээн байгуулалт шувтарч, үйлдвэрлэл нь мөдхөн эхлэх гэж байна. Говь нутгийн намар цаг дор “Оюутолгой”-н газар шорооны ажил шуударч, бүтээгдэхүүн үйлдвэрлэх үндсэн ажилдаа орж байгаа нь энэ. Өөрөөр хэлбэл, ирэх есдүгээр сар Оюутолгойн хувьд ололт амжилтаар дүүрэн байх бололтой.

Монгол Улсын нийгэм, эдийн засгийн амьдралд томоохон өөрчлөлтийн шинэ салхи үлээж, гадаад худалдаанд “Оюутолгой”-н бүтээгдэхүүн гэсэн шинэ шошго байр сууриа эзлэх гэж байна. Түүнтэй

зэрэгцэн Монгол Улс Уул уурхайн яамтай боллоо. Өөрөөр хэлбэл, Уул уурхайн салбар дангаар хөгжих, эс хөгжих учир зүйгээ өөрсдөө олно гэсэн үг. Ийм цаг үетэй “Оюутолгой” төслийн оргил цаг огтлолцож байна. Ил уурхайгаас анхны хүдрээ олборлож эхлээд буй төслийн бүтээн байгуулалт үндсэндээ 100 хувиа давжээ. Тун удахгүй анхны хүдрээ боловсруулахаар зэхсэн аж. Үршим нь эдийн засагт зах зухаасаа мэдрэгдэж буй “Оюутолгой” орд нь 2018 онд үйлдвэрлэл бүрэн жигдэрсэн үедээ дэлхийн гурван том зэсийн уурхайн нэг болох юм. Нэг үгээр хэлбэл, дэлхийн зэсийн нийлүүлэлтийн тодорхой хувь нь Монголоос хараат болж буй хэрэг. Уурхай эхний ээлжинд жилдээ 200 мянган тонн зэс үйлдвэрлэнэ. Тэгвэл үйлдвэрлэл бүрэн ашиглалтад орсоноор 450-500

мянган тонн зэс үйлдвэрлэхээр хар зураг буужээ. Одоогоос гурван жилийн өмнө “Оюутолгой” төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд хоёр тал гарын үсэг зурсан түүхэн цаг мөч балраагүй байна. Түүний тусгал эдийн засагт өсөлт гэсэн амжилтыг даллав.

Манайхаас даруй 860 дахин том эдийн засагтай Хятадын өсөлт саарч буй энэ үед Оюутолгой компани үйлдвэрлэлээ эхлэх нь. Учир нь, 2008 оны дэлхий нийтийг хамарсан эдийн засгийн хямралд хөл алдаагүй урд хөршийн өсөлт цуцав. Гэсэн ч хятадууд Монголын томоохон худалдан авагч хэвээр байна. Энэ л мөчид дэлхийн хэмжээний хөгжлийн төсөл сүндэрлэн босож байгаа нь тэр.

Уул уурхайн салбарыг тойрсон дагуул үйлдвэрлэл эрчимжиж, говь нутаг хэдийнэ Монголын тулах цэг ▶



► болчихсон байгаа нь айсуй хөгжлийн өнгө буй за. Оюутолгой, Тавантолгойн сүр бараа орон нутгийн бүүдгэр төрх, сүүмгэр амьдралыг ялимгүй өөд нь татав. Нар ээсэн налгар урт намраар говийнхон ч налайж суухаа хэдийнэ больжээ. Буцалж буй Ханбогдоос хөгжлийн нүргээн чих дэлсэж, өнгө будаг хосолсон шинэ амьдрал тэнд өрнөхөж. Хавтгайн “үрсад” болох хүрэн зандан тэмээний ширээ бөх ямархан зун болж өнгөрснийг давхар сануулна. Дэргэд Ханбогд ханарч хөлрөөд зон олны шүтээн уул зосон өнгөтэй зураг шиг сэтгэлд бууна. Ийм сайхан нутагт уул уурхайн салбар хөгжиж, улс орны амьдрал дэвжиж байгаа нь сайн хэрэг. Гэхдээ сайхан зүйл сайхан л байх ёстой. Сайхныг саараар булж, түүнийг бүдгэрүүлж боломгүй юм. Тиймээс орон нутгийн байгаль орчны асуудал оюутолгойчуудын анхаарлын төвд нь байхаас аргагүй. Ус, хөрс, өвс ургамал, экологийн тэнцвэрт байдал гээд байгаль орчны холбогдолтой асуудал бүхэнд “Оюутолгой” компани хариуцлагатай хандах учиртай билээ. Монголчууд ч дэлхийн жишигт нийцсэн нөхөн сэргээлт, байгаль орчны хамгаалал ямар байхыг эндээс харахыг хүлээж байгаа.

Компанийн нийгмийн хариуцлагын

хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сумын төвөөс 45 км-ын зайд мод үржүүлгийн газар бий болгосон нь сайн хэрэг. Энэ нь 640 ам.метр хэмжээтэй хүлэмжтэй, хашаалсан газартайгаа нийт таван га газрыг хамарсан талбай аж. Бут, сөөг, мод, төрөл бүрийн ховор ургамлыг “үйлдвэрлэж” байгаа нь чихэнд чимэгтэй мэдээ. Түүнчлэн үйлдвэрлэл өргөжиж, бүтээн байгуулалт хурдаа нэмэхийн хэрээр байгаль орчны хараа хяналт, экологийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүй байх чиглэлд “Оюутолгой”-н үйл ажиллагаа улам бүр чамбайран чиглэх учиртай. Тус компани байгаль орчны нөлөөллийн үнэлгээг олон улсын жишигт нийцсэн байдлаар боловсруулсан нь Монголдоо ланхных. Энэхүү баримт бичгийн агуулгад “Бид өөрийн нийгмийн хариуцлагын хүрээнд энэхүү баримт бичгийг боловсруулан гаргасны зэрэгцээ энэхүү үнэлгээ нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас төслийн санхүүжилт хийхэд тавигддаг нэгэн шаардлага байдаг. Баримт бичиг гаргах нь олон улсын санхүүгийн зах зээлээс хөрөнгө босгоход шаардагдах нэг үзүүлэлт” хэмээн цахим хуудсандаа онцолжээ. Товчхондоо, Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ нь тус компанийн

үйл ажиллагааг хэмжих хэмжүүр аж. Мөн зэрлэг амьтдад зориулсан цорын ганц гэж хэлж болохуйц нүхэн гарцыг Өмнөговьд барьж байгуулахаар зураг төсөл нь бэлэн болжээ. Уурхайд мэдээж ус ашиглана. Гэхдээ усны хэрэглээг хамгийн бага түвшинд байлгах боломжийг “Оюутолгой” төсөл эрэлхийлжээ. Нэг үгээр хэлбэл, хэрэглэсэн нийт усныхаа 84 хувийг дахин ашиглахаар болсон байна. Мөн Ханбогд сумын нутаг дахь дарагдсан, эвдэрсэн 20 гаруй хугдгийг засан сайжруулжээ. Өнгөрсөн хугацаанд усны хайгуулын ажилд 1.7 тэрбум төгрөгийг зарцуулаад байгаа аж.

Царцанги байсан эдийн засгийг гэсгээж буй уул уурхайн баялгийн шимээр манайх ирэх жилүүдэд эдийн засгийн өсөлтөөрөө дэлхийд цойлох нь тодорхой. Харин өндөр өсөлтөө тогтвортой хадгалж, тодорхой хөгжлийн замаар хурдлах нь төрийн бодлогын зүг чигээс хамаарна. Говийнхон урт намрын тэнгэр дор их ажлаа нугалж, хөгжлийн зах зухаас мэдэрч сууна. Ногоон эдийн засгийн хөгжлийн тухай тал бүрээс нь хэлэлцэж буй өнөө үед “Оюутолгой” төсөл үүнд ач холбогдол өгч байгаа нь уул уурхайн жишиг. Нэг үгээр хэлбэл, маргаашийн ногоон өсөлт өнөөдрөөс... ■